

МОНГОЛЧУУД АГНУУРТ ЗАНГА ХЭРЭГЛЭЖ БАЙСАН НЬ (Бидэнд олдсон нэгэн гар бичмэлийн тухай)

У. ЭРДЭНЭБАТ

МУИС, ШУС, Антропологи-Археологийн тэнхим,

e-mail: u_erdenebat@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГ: *Монголчуудын уламжлалт ан агнуур, агнуурын зэвсэг хэрэгсэл*

ТОВЧ АГУУЛГА: *Агнуурт занга тавьж агнах нь маш эртний хуучин аргын нэг юм. Монголчууд, хангай хөвчид тураг ан агнахдаа том хэмжээний нүх ухааж дээгүүр нь өвсөөр өнгөлөн битүүлээд түүн рүүгээ анг гэнэдүүлэн унагах, жижгэвтэр биетэй амьтанд шурган орох төдий хаалга, нүх гаргасан занга тавьж тэр нүхээр орж оньсыг хөдөлгөмөгц дээрээс нь хүнд юм унаж дарж алахаар зохион байгуулдаг байв. Хээр талын бүсэд ан амьтдын ус уух газар нүх ухааж амсарт нь хана тавьж далдлан бүрхээд анг тэр нүхэнд тээглүүлэн унагаж агнах зэрэг олон арга хэрэглэж байжээ. Сайль, занга, хаж мэтийн зэвсэг нь хүн малд онц аюултай тул яваандаа хэрэглэхийг төрийн хуулиар цаазлан хориглож, агнуурын багаж зэвсэг сайжран хөгжихийн хирээр орхигдон мартагдахад хүрсэн байна. Энэхүү өгүүлэлд өнгөрсөн зууны хоёрдугаар хагаст бичсэн “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх сонирхолтой гар бичмэлийг уншигч, судлаачдад зориулан нийтэлж байна.*

Монголын түүх, археологи, угсаатан судлал, соёлын антропологийн судалгааны нэгэн чухал сэдэв бол монголчууд болон тэдний өвөг дээдсийн хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцаж ирсэн түүх, тэдний аж ахуйн уламжлалт салаа мөчир - ан агнуурын төрөл хэлбэр, агнуурын арга, зэвсэг хэрэгсэл, тэднийг хэрхэн үйлдэж яаж ашиглаж байсан мэдлэг туршлага, ан агнахтай холбоотой зан үйл, шүтлэг бишрэл, хувьсал хөгжлийн асуудал юм.

Монголчуудын ан авын түүхэн уламжлалыг судлахад биет байдлаар хадгалагдаж үлдсэн археологийн олдвор, угсаатны зүйн хэрэглэгдэхүүн, түүхийн болон хэлний шинжлэл, хууль эрхзүйн дурсгалт эх бичиг, дүрслэх урлагийн бүтээл, гэрэл зургийн баримтуудаас гадна биет бус байдлаар үеэс үед дамжин уламжилсан ардын мэдлэг ухааны өв чухал ач холбогдолтой билээ. Үүнд, монголчуудын эртний агнуурын

тухай сайн мэдэх хашир туршлагатай ахмад анчдын ярьсан аман түүх, тэдэнтэй уулзаж явсан хүмүүсийн бичсэн тэмдэглэл, ном зохиолууд судалгааны үнэтэй хэрэглэгдэхүүн болно.

Амьдралынхаа сүүлийн жилүүдэд МУИС-ийн НШУС-ийн Археологи, Антропологийн тэнхимд зөвлөх профессороор ажиллаж байсан манай улсын ууган археологичдын нэг доктор Доржпаламын Наваан (1925-2009) багшийг нас барсны дараа хэсэг хугацаа өнгөрсөн хойно талийгаачийн гэр бүлээс хувьдаа хадгалж байсан хээрийн шинжилгээний зарим тайлан, бичиг баримтын зүйлийг бид хүлээн авсан юм. Энэ өгүүлэлд ярих зүйл бол буурал эрдэмтний бичиг сонин дотроос олдсон, монголчуудын ан агнах уламжлалт зарим зэвсэг хэрэгсэл, тэдгээрийг үйлдэх, хэрэглэх арга ажиллагаатай холбоотой, зохиогчийн нэр нь байхгүй нэгэн гар бичмэлийн тухай болно.

Энэхүү гар бичмэл нь А4 хэмжээтэй бичгийн цаасан дээр хөх өнгийн бэхээр кирилл үсгээр гаргацтай бичсэн 22 хуудас материал бөгөөд эхний 11 хуудсыг араб тоогоор 1-11 хүртэл дугаарлаж, дараагийн хоёр хуудсыг дахин 1-2 гэж дугаарласан, түүний хойно байх хоёр хуудсыг 8-9 гэж шинээр дугаарлаад үлдсэн 7 хуудсыг огт дугаар тавилгүй бичсэн, зарим хуудсан дээр ар өвөргүй, заримын нь зөвхөн нүүрэн талд бичсэн, хооронд нь хоёр зэс хавчаараар нийлүүлэн үдсэн нийт 37 тал эх бичвэр юм.

Гар бичмэлийн эхний хуудасны толгой талд “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх гарчиг тавьсан байх ба түүний хажууд хөндлөнгөөр ром тоогоор VII гэсэн дугаар тавьснаас үзэхэд ямар нэг зохиолын VII бүлгийн ноорог байсан гэмээр. Уг гар бичмэл нь зохиогчийн шууд өөрөө гараараа бичсэн бүрэн гүйцэд боловсруулаагүй ноорог учраас зарим газар утга санаа давхардуулсан, зарим газар шинэ зүйлийг хөх бэхээр нэмэн бичиж засварлах, эсвэл зарим үг үсгийг дарж баллах зэргээр бага зэрэг засвар хийсэн байна. Түүнчлэн зохиолын дотор гурван хэсэг газар зураг оруулахаар төлөвлөж байсан бололтой сул зай үлдээжээ.

“Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх бичмэлийг зохиогч нь монголчуудын уламжлалт ан агнуурын тухай өндөр мэдлэгтэй, хуучны хашир туршлагатай олон анчинтай уулзаж учирч явснаас гадна бичиг үсгийн боловсрол сайтай, шууд найруулан бичих авьяастай хүн болох нь үзтэл илэрхий. Кирилл үсгээр бичсэн боловч хуучин монголтой хүн байсан бололтой. Тухайлбал, үнэг гэхийг - үнигэ, булга - булага, өмх - өмөх, дах - даха, ходоод - ходгоод, тэвх - тэвхэ, пүнз - фүнз, оньс - онис, өндөр - өндэр, хөрс - хөрөс, шургааг - сургааг, амьдрал - амьдарлаг, давчуу - тавчуу, нааш цааш - найш цайш, хааш хаашаа - хайш хайшаа, гэрэл гэгээтэй - хэрэл хэгээтэй, тавьдаггүй - тавидаг үгүй, хатгасан - хатагсан, мултарч - молтарч, гишгэх - хишгэх, хөшүүргээр - хүшүүргээр, шүргэхэд - сүргэхэд, өмнөхөн - өмнэхэн, түгжигдэнэ - дүгжигдэнэ гэх зэргээр шинэ үсгийн зөв бичих дүрмийн хувьд жаахан алдаатай бичжээ.

Яагаад зохиогч нь үл мэдэгдэх гар бичмэл хэмээн үзэж байна вэ гэвэл, нэгд, уг бичвэрт үүнийг хаана, хэн, хэзээ зохиосон тухай өгүүлсэн мэдээ байхгүй, хоёрт, бичгийн хэв нь Д.Наваан гуайнх биш, гуравт, зохиолын дотор хэд хэдэн газар “би” гэж нэгдүгээр биеийн төлөөнөөс бичихдээ, тодорхой он сар ба нутаглан сууж байсан газар усны нэрийг дурдсан нь ахмад археологичийн намтар түүхтэй таарахгүй байгаа юм.

Тухайлбал, гар бичмэлийн дотор зохиогч өөрийн тухай өгүүлэхдээ: “1923 онд манайх Тэрэлжийн Шар дэвсэг газар өвөлжсөн тэр өвөл манай айл өвөлжсөн айлуудын дунд Хэрэмчин Жамьян хэмээх шинэ залуу анчин байлаа. Би түүнийг дагаж өдөр бүр хол ойр хэрэм агнахыг сурах санаатай явдаг байлаа. Ингэж явахдаа Бага Мухарын модон дотор ойр хавийг томог тавьж хаасан зангыг нүдээр үзэж тэр үед юу болохыг мэдэхгүй Жамьянгаас асуусанд, занга гэдэг юм гэж анх удаа мэдэж авсан юм. Ингээд зангыг хэрхэн тавьдаг, энэ занга ямар анд тавьсан зэргийг бүрэн мэдэх болсон... Дараа өвөл нь Хойд Сайханд байхад хөвчийн алдартай анчин Зөрүү Дорж, Дэндэв нар миний ах Шаравтай анд гарахаар манайд ирж ангийн тухай урьдын нэртэй сайн анчдын тухай өөрөө Заанд занга тавьж байсан зэргээс сонсоход миний үзсэн занга зэргийг оролцуулж байв. Би тэр үед бага байсан учир тэдний ярианд орох байтугай асуух ч эрх зэрэгт хүрээгүй байлаа” гэсэн ба 1967 оны 11 сард музейн ажлаар Говь-Алтай аймагт ажиллаж байснаа дурсаж бичсэн байна. Эндээс бодож үзэхэд, зохиогч Туулын эх, Заан Тэрэлж хавиар нутаглаж байсан бололтой бөгөөд хэрэв 1923 онд хэрэм агнахыг сурахаар явж байхдаа 10 гаруй настай хүүхэд байсан хэмээн таамаглавал 1967 онд наад зах нь 60 шахам настай хүн байжээ. Мөн өөр хэсгүүдэд: “1929 онд Амгалангийн 6-р хорооны дарга байсан Хамниган Адьяа тэр үед ярьж байсан”, “Шортой занга, жадтай занга, сөрлүүрт занга гэж байсан гэж 1930 онд Хөвсгөл аймгийн харьяат аль сумынхы нь мэдэхгүй өвгөн анчин Томой гуай надад ярьсан юм” гэх зэргээр он цагийг тэмдэглэсэн ажээ.

Гэтэл Д.Наваан багш бол 1925 онд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Могойн Бор хөндий гэдэг газар төрсөн хүн юм. Түүнээс гадна энэ бичвэрийг зохиогч хоёр ч газар доктор Н.Сэр-Оджавын нийтлүүлсэн археологийн материалаас эш татан дурдаж оруулахдаа хадны зураг болон буган хөшөөн дээр байдаг зарим дүрслэлийг монголчуудын ан гөрөөсөнд тавьж байсан нэгэн зүйлийн зангатай харьцуулан үзсэн нь Москвагийн Улсын Их Сургууль төгсөж, олон жил ажилласан хур их туршлагатай Д.Наваан багш шиг мэргэжлийн археологичийн бичих зүйл арай биш мэт санагдав. Жишээлбэл, гар бичмэлийн зохиогч хүрэл, төмрийн түрүү үеийн буган хөшөөнд байдаг бамбайн дүрслэлийг байшингийн орой шиг шовгор гурвалжин хэлбэртэй өмсгөл занга баймаар байна, бугын дүрслэлийг энд байгаа буга занганд дарагдах шинж тэмдгийг ойлгуулахын тулд урд хөлөө бохирч байгаагаар зурсан бололтой гэсэн санал дэвшүүлжээ.

Тэгэхээр энэ гар бичмэл археологич Д.Наваан гуайнх биш бөгөөд зохиолын дотор хамгийн сүүлд гарч байгаа 1968 оноос хойшхи хугацаанд бичгийн чадвар сайтай, өөрөө олон жил ан ав хийж явсан туршлагатай юмуу эсвэл тийм хашир анчин хүмүүсийг сайн таних өөр хэн нэгэн тэмдэглэн бичсэн хэмээн үзэж болно.

1960-1980-аад оны хооронд Ж.Дамдин, Ш.Бадам, Ш.Гонгор, С.Лувсан нарын зэрэг нэр цуутай хэд хэдэн анчны тэмдэглэл ном хэвлэгдэн гарсан байдаг (Дамдин 1958, 1963, 1975; Даш, Гонгор 1965; Бадам 1965; Лувсан 1986). Энэ хэдэн зохиогчийн дотроос Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын харьяат Жүгдэрийн Дамдин (1888-1980) гуай нь 19 настайдаа Нийслэл Хүрээний газар ирж Эрдэнэ Шанзовын үүдний тусын бичээч, 1921 оноос өөрийн үндсэн нутагт отгийн даргын газрын бичээч байснаас эхлэн 1967 он хүртэл ардын цэрэг, нам эвлэл, Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл, Шүүх прокурор, Шинжлэх Ухааны Академийн харьяа газруудад хариуцлагатай ажил хийж явсан бичгийн боловсрол сайтай хүний нэгэн болох

ажээ (Монгол ардын журамт цэргийн дуртгалууд 1982: 567).

Партизан Ж.Дамдин бол хашир анчны зэрэгцээ “Ховор амьтны мөрөөр”, “Буурал анчны тэмдэглэл”, “Эх орон”, “Монгол бөх”, “Үймээний жил”, “Анчны тэмдэглэл”, “Сэлэнгийн урсгал”, “Морьт цэргийн явсан зам”, “Буун дуу”, “Замын эхэн” хэмээх олон тооны ном товхимол, өгүүллэг найруулал хэвлүүлсэн зохиолч байсан юм. Түүнээс гадна гар бичмэлд өгүүлж байгаа, гахай агнадаг хуга мэсэн хүүлүүр гэгчийн тухай дээрх хэдэн анчны дотроос гагц Ж.Дамдин гуай л “Буурал анчны тэмдэглэл” номондоо дурдсан байдаг (Дамдин 1963: 85-86). Мөн найруулан бичих арга барил, нас сүүдэр, намтар түүх хийгээд анчны туршлагын хувьд Ж.Дамдин гуай уг гар бичмэлийн зохиогч байх бололцоотой мэт боловч бидний нийтлүүлэн буй бичмэлийн төгсгөл хэсэгт ийм сонин хачин аргаар гахай агнаж байсныг нүдээр үзэж байсан тул тодорхой ярьж өгсөн хүн гэж түүнийг өөрийг нь нэр заан дурдсан байна. Иймээс Ж.Дамдин тус гар бичмэлийн зохиогч байх боломжгүй болж байна.

Харин гар бичмэлийн зохиогч бичвэртээ Улсын Төв Музейд чихмэлчин ажилтай Самдан гэдэг хүний нэрийг дөрвөн удаа дурдаж, өөрөө музейн ажлаар 1967 оны 11 сард Говь-Алтай аймагт ажиллаж байснаа эргэн дурссанаас үзэхэд Улсын Төв Музейн ажилтнуудтай ойр дотно харилцаж байсан, тэр ч байтугай өөрөө музейд ажиллаж байсан хүн байж болзошгүй санагдав.

Түүхч эрдэмтэн Д.Гонгорын 1978 онд нийтлүүлсэн “Халх товчоон” хэмээх дорвилог бүтээлийн 2-р ботид монголчуудын агнуурын арга барил, багаж зэвсгийн талаар нэлээд нарийвчлан өгүүлсэн нэгэн тэмдэглэлийн тухай ярьсан байна. Д.Гонгор гуай уг тэмдэглэлийн зохиогчийг С.Төмөр-Очир гэж хэлсэн боловч зохиолыг нь номондоо эшэлж оруулаагүй, номзүйн дотор ч энэ “тэмдэглэл”-ийн нэр алга байна.

Д.Гонгор гуай бичихдээ: “С.Төмөр-Очирын Монголчуудын ан агнуурын тухай бичсэн нэгэн тэмдэглэлд агнуурын арга барил, багаж зэвсгийн талаар нэлээд нарийвчлан

өгүүлжээ. Сурвалж бичиг, уул тэмдэглэл зэргээс үзэхүл эрт, дундад үед монголчууд агнуурт нум сум, урхи, бүдрэг, унанги, занга, дүүгүүр хананга, хавчарга, хаж, сайль, хавх, буу зэргийг хэрэглэж байжээ.

Нум сум гарсан нь гагцхүү агнуурт төдийгүй дайснаас хамгаалах найдвартэй зэвсэг болжээ. Археологийн судалгаагаар тус орноос дуут зэв (исгэрэх), хоёр ба гурван дэлбээт зэв олноор олдсон бөгөөд эдгээрээс агнуурт үсний ангийн буюу болцуут зэв, ойр холын хүнд хөнгөн зэвүүд хэрэглэж байжээ. Эртний хятадын сурвалж бичигт монголчуудыг “нум сумтны улс” гэж өгүүлсэн байдаг.

Урхийг ангийн ус уух нуур, голын хөвөө эргэнд тавих бөгөөд хөлийн, хүзүүний хоёр төрөл байсан ба хөлийн урхи нь шууд, мунат, чиргүүлт, аргамжаат, дүүжин урхи гэж байжээ. Түүнчлэн хулан, тахь зэрэг амьтдыг цалам бугуйл, уургаар барих ажээ. Нүх ухааж амсрыг өвс зэрэг зүйлээр таглаж идэгшүүлэн анг гэнэсэргүй унагаахыг *бүдэрэг* гэнэ. Бүдэрэгийг хөвч хангайд “*унанга*” зарим нутагт “*яам*” гэж нэрлэх нь буй. Бүдрэгээр буга, хандгай, гахай зэрэг тураг гөрөөс агнана. Намрын сүүл сарын үед анхны цас ороход халуун сэрэг мөр буюу ан олж хоёр, гурван хоног дагаж өртөөлөн явсаар цуцаан ядрааж агнахыг “*богжоох*” гэнэ. Энэ аргыг Ерөө голын хамниган нар хэрэглэж байжээ.

Занга бол нэлээд дэлгэрсэн зэвсэг юм. Энэ нь дарах, цохих, томогт, торог-бөгжин, хавчуур, хөмрөг-өмсгөл, шорон-жадат занга гэж байжээ. Зангыг гол төлөв ойд хөвчид төрөл бүрийн ангийн бие бялдар, бяраа чадал харгалзан тохируулж тавина. Мөн дүүгүүрийн хүчээр чулуу шидэж агнана. Ардын аман уламжлалд “шөрмөсний хүчнээр шагай чинээ чулуу хонины хүчийг олдог, аргамжийн хүчнээр аргалын чинээ чулуу адууны хүчийг олдог” гэхчлэн өгүүлнэ.

Хээр талын бүсэд хананги, хавчирга хэмээх хоёр төрлийн багаж хэрэглэж байжээ. Ангийн усны газрыг тохиолдуулан газар ухааж нүхний амсарт хана тавьж далдлан бүрхээд анг түүний нүхэнд сөхрүүлэн тээгэлдүүлэн унагаахыг “хананги” гэнэ. Хавчирга бол

ангийн хөл хавчиж барих зэвсэг бөгөөд энэ нь улмаар хавх болсон бололтой.

Хаж хэмээх зэвсгийг говь тал нутагт хэрэглэж байсан нь мод, чулуун мунат, чиргүүл, аргамжаат гэх мэт бөгөөд үүгээр зээр гөрөөсний хойд хоёр хөлийн шөрмөсийг тас огтолож барих ажээ. Хуульч Сандагийн зохиолд “Хажинд орсон зээрийн үг” гэж буй. Түүнд “Мэнэнгийн талд нутагтай билээ. Манхан тэнгэр эзэнтэй билээ... Хорин түмэн нөхөд мину хошуурсаар далд оров. Хоёр борвигүй би чинь хойноос нь хараад хоцров оо” гэж хөөрхийлэлтэй өгүүлнэ” гэх зэргээр дурджээ (Гонгор 1978: 349-350).

Д.Гонгор гуайн номноос үзэхэд, монголчуудын ан агнуурын тухай бичихдээ, дээрх С.Төмөр-Очирын “тэмдэглэл” гэдгээс нэлээд зүйлийг уншиж ашигласан бололтой бөгөөд ялангуяа хөвч хангай, тал хээрт хэрэглэж байсан олон төрөл зүйлийн занганы тухай тоочин өгүүлсэн нь анхаарал татаж байна.

С.Төмөр-Очир гэж хэн байв аа гэвэл, 1970-аад оны сүүлч болтол Монголын музейн салбарт ажиллаж байсан хүн бөгөөд тухайн үед гарч байсан “Музей судлал” сэтгүүлд “Улсын Төв Музейн үзмэрт байгаа гал асаагуурын мод” (Төмөр-Очир 1968: 55-59), “Улсын Төв Музейн үүсэж хөгжсөн түүхээс” (Баарай, Төмөр-Очир 1974: 4-23), “Улсын Төв Музейд байгаа нэгэн тугийн тухай” (Төмөр-Очир 1977а: 38-44), “Монголчууд галт зэвсэгтэй болсон нь” (Төмөр-Очир 1977б: 68-71) зэрэг эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэл нийтлүүлж байсан, олон талын мэдлэгтэй, авьяаслаг нэгэн байжээ.

Монголын музейн хөгжлийн түүхэнд холбогдох архивын баримт бичгийн эмхэтгэлд үзэхэд Төмөр-Очирын нэр 1931 оноос эхлэн гарч байх бөгөөд тэрбээр Шинжлэх Ухааны Хүрээлэн ба харъяат музейн бүртгэгч, тусгай төлөөлөгч, коминдант, 1966-1972 оны хооронд БНМАУ-ын Соёлын яамны дэргэдэх Музейн зөвлөлийн гишүүн, Улсын Төв Музейн үзмэрт үнэ тогтоох ба үзмэр худалдан авах зөвлөлийн дарга, гишүүн зэрэг хариуцлагатай ажил хийж явжээ (Монголын музей 2012: 28-29, 39, 218-

225, 230-231, 270, 297). Тэрбээр музейн салбарт олон жил ажиллахдаа тухайн үеийн төр засгийн шийдвэрээр хураагдсан феодалын эд хөрөнгөнөөс зохих зүйлийг Шинжлэх Ухааны Хүрээлэнд шилжүүлэн авах, хөдөө орон нутгаар явж музейн сан хөмрөгт шинэ үзмэр цуглуулах, ард иргэдийн гарт хадгалагдаж байгаа түүх соёлын ховор нандин өв дурсгалыг сурвалжлан олж музейн үзмэрт худалдан авч баяжуулах, тэдгээрийг дансалж бүртгэн тодорхойлон бичихэд хичээл зүтгэлтэй ажиллаж байжээ.

Зөвхөн ганц баримтыг жишээ болгон дурдахад, 1935 оны 11 дүгээр сарын 23-нд бичсэн “Төмөр-Очироос харьяа Шинжлэх Ухааны хүрээлэн ба харьяат музейд шилжүүлсэн зүйлс” хэмээх бичигт: “Энэ оны 10 дугаар сард тус музейн цуглуулгын ажлаар Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Архангай зэргийн дөрвөн аймгаар явсан ажлын дүн болон олж ирсэн зүйлүүд ба бусдаас сонсож тэмдэглэсэн тэмдэглэл зэргийг тус тус 2 хувь үйлдэж харьяа газраа тус бүр нижгээд хувийг тусгай хавсаргаж хянан үзэхүй дор бэлтгэн толилуулахаас гадна эдгээр юмуудыг цөм үнэгүйгээр олж ирсэн болохыг хамтатган мэдэгдье. Тус музейн бүртгэгч Төмөр-Очироос музейн цуглуулгын хэргийг архивын эрхлэгч Цогтжамбалын хамт явж Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Архангай зэрэг дөрвөн аймгуудаас олж ирсэн зүйлийг тус музейд шилжүүлэв” гэсэн ба музейн үзмэрт шилжүүлэн авсан хуучин цэргийн хуяг дуулга, хувцас хэрэглэл, нум саадаг, гунан буу, бурханы шашны хурал номын хэрэгсэл, хувцас хунар, хөгжмийн зэмсэг, хуучны эрүү шүүлтийн зүйл, туг далбаа зэрэг 57 дэсийн нийт 173 ширхэг эд өлгийн зүйлийн бүртгэлийг хавсаргажээ (Монголын музей 2012: 297-304).

С.Төмөр-Очир гуайн хэвлүүлсэн өгүүлэл болон музейн үзмэрт хийж байсан тодорхойлолт бичгүүдийн хэл найруулга, бичгийн хэвийг бидэнд олдсон “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх гар бичмэлтэй харьцуулан үзэхэд нэг хүнийх мэт байна. Түүнээс гадна, түүхч эрдэмтэн Д.Гонгор гуай “Халх товчоон”-доо, монголчуудын агнуурын

арга барил, багаж зэвсгийн талаар нэлээд нарийвчлан өгүүлсэн тэмдэглэлийн зохиогчийг С.Төмөр-Очир гэж цохон заасан нь бидний өгүүлж буй гар бичмэлийн агуулгатай тохирч байхын зэрэгцээ цаг хугацааны хувьд ч С.Төмөр-Очирын идэвхтэй бичиж туурвиж байсан үетэй таарч байна. Тэгэхлээр тус гар бичмэл нооргийн дотор хамгийн сүүлд гарч байгаа 1968 оноос хойш “Халх товчоон” бүтээлийн 2-р боть хэвлэгдэн гарсан 1978 оны хоорондох цаг хугацаанд музейн ахмад ажилтан Самдангийн Төмөр-Очир гуай энэхүү тэмдэглэлийг бичсэн байж болох юм.

Нийгэм ахуй хөгжиж агнуурын зэвсэг хэрэгсэл улам боловсронгуй болохын хирээр ан агнах уламжлалт арга, зэвсэг хэрэгсэл, зан үйл улам орхигдон гээгдсээр иржээ. Түүнээс гадна хүний болон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай гариг дэлхий дээр зэрлэг ан гөрөөс, араатан жигүүртэн улам бүр ховордож буй өнөөгийн нөхцөлд амьтны амь таслах, цус гаргахыг соёлт хүн төрөлхтөн таашаахаа больж байна. Ийм нөхцөлд зэрлэг амьтныг агнахтай холбоотой ардын уламжлалт мэдлэг ухаан яваандаа газар сайгүй бүрмөсөн мартагдаж эртний агнуурын арга барил, багаж зэвсгийн төрөл зүйлийн талаар мэдэх ярих ч хүн үгүй болох биз.

Иймээс монголчуудын эртний агнуурын арга барил, багаж зэвсгийн зарим төрлийн тухай өмнө хэвлэгдсэн анчин гөрөөчний тэмдэглэлүүд хийгээд эрдэмтэн судлаачдын бичсэн ном зохиолд ч дурдаагүй өнгөрсөн сонирхолтой мэдээ үлдээсэн энэхүү гар бичмэлийг ганцхан өөрөө хав дараад байлгүй олон түмэнтэйгээ хуваалцъя гэж бодсон билээ. Ингээд зарим үг үсэг нь тодорхойгүй болж хуучирч шарласан бичмэлийг олны үзэж судлахад дөхөм болгож орчин үеийн монгол хэлний кирилл үсгийн зөв бичих дүрэмд нийцүүлэн засаж сийрүүлэн толилуулав.

[fol.1 recto¹] АГНУУРТ ЗАНГА
ХЭРЭГЛЭЖ БАЙСАН НЬ

Зангыг эрт цагаас өргөн хэрэглэж ирсэн бололтой. Үүнд: дарах занга, цохих занга, томогт занга, торон занга, хориг занга, хашаан занга, хавчуур занга, хөмрөг буюу өмсгөл занга, шорт буюу жадтай занга гэх зэрэг олон төрлийн зангуудыг газар орны байдал түүнд хэрэглэгдэх материалын байдалд тохируулан тухайн нийгмүүдийн хөгжлүүдийн дагуу янз бүрийн занга гарч хэрэглэгдэж байжээ.

Хэрэглэхдээ ан амьтны байдалд тохируулан булган занга, үнэгэн занга, чонын занга, чандаган занга, хүдэрийн занга, гахайн занга, баавгайн занга, буга-хандгайн занга гэж олон төрлийн ангийн нэртэй түүнд буюу түүнтэй ойролцоо анд тус бүрийн хэмжээнд тохируулан хүнд хөнгөн маяг хийц зохион байгуулалт нь өөр өөр байдаг байна. Орчин үед тэр бүр зангыг тавьдаггүй болжээ. Ер нь сайль, занга зэрэг дарах, харвах зэвсэг нь амьтан, хүмүүсийн амь насанд хөнөөл хүргэдэг учир эртнээс аваад хуулиар цаазлан хориглосон зэвсэг юм.

А. Булган зангын тухай товч өгүүлэх нь.
Булга маань манай орны Хэнтий, Хөвсгөлийн ой тайга түүний салбар уулаар элбэг оршсоор ирсэн тул эрт цагаас үсний гоёмсог сайханд болж дотоод гадаадын хэрэгцээнд зориулж агнасаар иржээ. Зарим газрын булга хар, мөнгөн сортой хар байхад зарим газар хүрэн, цайвар шаргалдуу байдаг юм. Булгыг ажиглахад идшинд гарахдаа өвлийн жавартай хүйтэнд голдуу газрынхаа нам доод тал [fol.1 verso] уруугаа гүйдэг. Хэвтэр үүр рүүгээ буцаж газрынхаа өөд гүйх жишээтэй байх бөгөөд манан будантай дулаавтар үед өдрийн цагаар ийш тийшээ хамаагүй гүйдгийг анчид мэддэг юм. Байрших газар нь хад асганы хөндий, өмх модны хонгилд үүрлэдэг байна. Булга нь тогтворгүй үргэлж хурдан хөдөлгөөнтэй, агнахад хэцүү амьтны нэг бөгөөд гагцхүү үсний сайханд хүмүүс эртнээс

агнаж гоёлын хувцас хунарт (дах) эрхэм болгон хэрэглэх буюу бэлэг дурсгалд өгдөг тул бусад ан амьтантай жишихэд төдий л элбэг биш байсаар иржээ. Харин ардын засгийн жилүүдэд агнахыг хуулиар цаазлан хориглосон учир одоо элбэгшжээ. Булгыг агнахад бусад ангаас хэцүү, хад асганы завсар хөндийд гүйж орох буюу модонд гарах зэргээр баригдахгүй олодохгүй болдог амьтан тул нохойн тусламжтай агнахаас гадна, эрт дээр цагаас янз бүрийн зангаар агнах явдал өргөн хэмжээтэй дэлгэрсэн байна.

Булга агнуурт янз бүрийн олон төрлийн занга тавьдаг байсан бололтой. Үүнд: голоороо 50 см-ээс 1 м бүдүүн бөгөөд шулуун ширхэгтэй модыг нэг, хоёр буюу 2 м хэмжээтэй урт тайрч голоор нь цуулж хоёр тал болгоод өө сэвийг авч засаад цуулсаны нэг талыг тэгшхэн өөд нь харуулан хөдөлгөөнгүй ул суурь болгон тавиад нөгөө талыг уруу нь харуулан хуучин эвээр нь нийлүүлэн тавьж шалгаж үзээд дээд талын модны буланг өргөхөд ухарч гулгахгүйн тулд өшиглүүр торомж гаргах буюу эсвэл гадас зэрэг зүйлээр тогтоож тавьдаг байна.

Ингээд талын үзүүрийг 30-40 см ангайлгаж сөхөж тэвхдээд тэвхний үзүүрт адууны мах буюу шар тосны гүзээ хатгаж [fol. 2 recto] дотогш нь харуулан тавьдаг бөгөөд мах тосны үнэрээр дэргэдүүр нь дахин дахин эргэлдэж гүйсэн булга нь сүүлдээ дасаж харгүй болсон хойноо мах буюу тосны гүзээг идэхээр занга модны хагархайн завсраар орж шор тэвхний үзүүрт хатгасан махыг татахад тэвх нь мултарч хоёр мод хоорондоо нийлэн хавчиж алдаг. Үүнийг *хавчуур занга* гэдэг юм.

Булганд бас *торон* буюу *хайрцаг занга* гэж байдаг байна. Ийм занганд орсон булга ямар ч гэмтэлгүй амьдаар барихад зориулж хийсэн жижиг хайрцаг шиг сав бөгөөд нэг талдаа хаалгатай, хаалга нь дотор талаасаа хаагдан түгжигдэх зохион байгуулалттайгаар хийж хаалганы шорон тэвхэнд идэх юмыг хатгаж тавина. Гадуур ирж дассан булга дотор

¹ Эрдэм шинжилгээний ном зохиолд, ямар нэгэн гар бичмэлийн ар өвөргүй бичсэн хуудасныхаа (folio – цаасны хэмжээ гэсэн

латин үг) өмнө (recto – нүүрэн тал гэсэн латин үг) буюу хойно (verso – ар тал гэсэн латин үг) байгааг ингэж ялган тэмдэглэдэг (У.Э.).

нь орж идэх зүйлээс зулгаахад тэвх нь бууж хаалга нь түгжигдэн хашдаг байна. Эдгээр хоёр төрлийн зангыг чулуугаар ч хийж болдог байна. Ялангуяа, хайрцаг сав хэлбэртэй зангыг чулуугаар барих нь мэрж цоолж гарах аюулгүй сайн талтай байдаг байна.

Ер нь зангыг урин дулаан цагт барьж байгуулаад нэлээд хуучирсны дараа идэх юм хийж дасгаад дараа сор ноолуур нь гүйцсэн ашигтай цагт тэвхийг нь тавьж барих агнах ажилдаа ордог байна. Ийнхүү байнгын зангыг хэрэгтэй үедээ тэвхий нь сойж идэх зүйлийг нь тавих нь сая шинэ тутам барьж байгуулсан зангыг бодоход илүү ашигтай байдаг байсан тухай Ерөө голын эх Шарлангаар нутаглаж байсан хамниган анчин Бат гуай ярьж байсан юм. Хэрвээ модоор хайрцаг тавихад хүрвэл тогтмол эргэж байх ажил нэмэгддэг. Учир нь булга шүдээрээ мэрээд гардаг тал байдгийг анхаарууштай юм шүү гэж байж билээ. Ийм эртний аргын үлдэгдэл нь манай ойн анчдын дунд 1931 он хүртэл зарим нэг газар хэрэглэгдэж байсан байна.

[fol. 2 verso] Б. *Үнэгэн занга*. Үнэг агнадаг занга бол чулуугаар барьсан сав буюу пүнзэн хориг занга байх бөгөөд ийм зангууд Говь-Алтай аймгийн говийн нутагт элбэг энд тэндгүй үзэгддэг юм. Жишээ нь, мөн аймгийн Цогт сумын нутаг Захуй бригадаас 120км Шивээт Улааны өвөр, мөн Эрдэнэ сумын нутаг Идрэнгийн нурууны Тэргэн Хараас хойш, Алтай сумын нутаг Аж Богдын салбар уул Хар Хайрханы ар завсарын ус, мөн өвөрт тус тус ийм чулуун занга байдаг. Эдний урт нь 1 м зайтай, өргөн нь 40 см, өндрийн зай нь 50 см, гонзгой талын нэг буланд үнэг элбэг багтаж орох үүд нүх гаргаж дотор талаас хаагдах чулууг тусгай тэвхээр сойж тогтоосон битүү сав байх бөгөөд тэвхний үзүүрийг занганы мухарт байхаар зохион байгуулж тэр үзүүрт мах шорлон хатгаж тавина. Үнэг махыг идэхээр орж шортой махнаас зулгаахад тэвх мултарч хүнд чулуун хаалт үнэгний сүүлийг даран унахад дотор нь нэгэнт орсон үнэг эргэж гарах байтугай хөдлөж чадахгүй хаагдаж байх юмуу үхдэг байна. Бас үүнээс өөр хаалт сойлтоор агнадаг ч ёс байдаг байна.

Ийм зангууд нь эрт дээр цагаас гаралтай оньсон зэвсэг бөгөөд одоо нэгэнт төрөл бүрийн агнуурын боловсон багаж зэвсэг бий болсон учраас нийгмийн хэрэгцээнээс нэлээд дээрээс хасагдсан байна. Харин говь газрын үнэгний занга нь бусад амьтанд хортой биш учир зарим тохиромжтой газар хэрэглэхэд онц хоцрогдсон биш бололтой юм.

[fol. 3 recto] В. *Чулуун занга. Янгирын чулуун занга*. Монгол Алтай, Говийн Алтайн сүрлэг хад ууланд элбэг байдаг ямаан гөрөөс (янгир) зуны халуун өдөр том ханан хадны ар сүүдрээр, өвлийн хүйтэн улиралд хадны өвөр, агуй хонгил нөмөр дулааныг дагаж хэвтдэг, зарим газар байршин тогтмол хоноглодог тул ийм газрууд нь малын хэвтэр шиг зузаан бууц өтөгтэй болсон дулаан хэвтэрүүд олон байдаг тул энэхүү тогтмол газар нь том том чулуу өрж тусгай тэвхээр тогтоож тавьж байсан гэдэг. Энэ хэцүү ажиллагаатай амжилтаар сайн биш арга байсан гэдэг яриа байдаг. Чухам тавьж байсан хүн байдаггүй. Ярианаас үзэхэд хэвтэрт ирсэн олон янгир багтаж ядан томууд нь урьдаар байраа эзлэн хэвтээд авсны дараа багачуул нь тойрч хадны чөлөө зайгаар явах буюу хэвтэхэд нь нөгөө занга тогтоосон тэвх торомжинд хүрч мултрахад нь дор хэвтэж байсан янгирүүд чулуунд цохигдож үхдэг бололтой.

Над ийм занга гэмээр зүйл тохиолдож байсангүй. Харин хад чулуу нь нурсан агуй бишгүй байдаг юм. 1967 оны 11 сард музейн ажлаар явж байхад Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутаг Дэвэрхийн амны Зүүн амны хадны хонгилд хэвтэж байсан янгирын том тэх дээр хад хагарч унаад цохиж алаад яс нь арьсандаа хатсан байдгаас үзэхэд янгирт цохиж алах чулуун занга тавихад үр ашгаа өгч болмоор тул эрт дээр үед ийм аргаар агнаж байсан байх боломжтой байна.

[fol. 3 verso] Г. *Гэхай ба тургийн занга*. Модоор занга зүүхдээ ямар анд зориулж байгаагаар тус бүрийн алхаш гишгэш, хэмжээнд тохируулж тавихаас гадна эдгээрийн явах зөрөг зам улирлын байдлаар өөр өөр газраар явдаг, мөн ан төрөл тус бүртээ зөрөгтэй байдаг тул түүнийг олж тавьдаг байна.

Ер нь зангыг зүүхдээ манай оронд заавал босго буюу дэр хөндлөн урт мод ангийн явах зөрөг дээр яр гишүүгүй болгож гахайд бол босгыг газарт намхан суулгана. Буга, хандгай зэрэг том биетэй тураг анд бол арай өндөр, зарим занганы босгыг харайх, заримыг алхаж гарахаар байрлуулж тавина.

Ингэж зангыг зүүгээд нэлээд хугацаанд орхиж түүгээр аль нэг төрлийн анг явж дассаны дараа мөнхүү босго модны дагуу хавчин дарж унахаар бодож чанх дээр нь 4-6 м урт, 20-25 см бүдүүн нойтон гуалин хоёроос гурвыг давхарлан бие биетэй нь холбож баавгай, тураг, гахайд тэр бүрийн хэмжээнд тохируулан тэр анг доогуур нь гарахад ямар ч саад болохооргүйгээр хөндий тавьж нэг буюу хоёр, үзүүрт тусгай мултрах тэвхээр эдгээр олон хүнд гуалинг тогтоож аль нэг тэвхийн сойлтонд хүрэхэд урьдчилан мултрахаар анд сэжиг авахааргүй бат бэх нарийн хялгас зэрэг оосор торомж хийж ангийн гишгэхэд юмуу эсвэл хөл цээж хэнхдэгийн аль нэг биеийн хэсэгт зөөлөн хүрмэгц сойлт нь мултарч маш хурдан ангийн нуруун дээр унаж ууц нурууг хуга даран алдаг байна.

Харин гишгэхэд мултрах сойлт торомжийг навч холтсоор хөнгөн хучиж орхих ба хөл буюу хэнхдэг хавиар [fol. 4 recto] мултрах торомжийг тэр хэмжээнд сул чангыг тохируулан тавина. Татуургы нь чанга тавивал цээж хавиар, сул гогцооруулан тавивал ууц хавьд занга унадаг байна.

Ийм занганд цохиулсан аливаа ан хэмх даруулдаг. Хэрвээ гахай бол дөрвөн хөл нь нугарахгүйгээр шаасан гадас шиг газар шигдэн орсон байдаг гэж занга зүүж тавьж байсан эртний олон анчид ярьдаг юм. Археологич эрдэмтэн Сэр-Оджавын олж илрүүлсэн хадны олон зураг баримтуудын дотор “Монголын хүрлийн үе” номын 55-р хуудсанд байгаа зургууд нь ямар нэгэн урхи, дарах, харвах занга буюу түүний тэвх оньс байж болохоор байна. Тэр учраас энд байгаа буга занганд дарагдах шинж тэмдгийг ойлгуулахын тулд урд хөлөө бохирч байгаагаар зурсан бололтой. Гахай бол хичнээн хүнд занганд дарагдсан байлаа ч дөрвөн хөлөө огт нугалдаггүйгээр өвлийн

хөлдүү газар ч шаасан гадас шиг шигдэн орсон байдаг гэж Хүүхэн ноёны отгийн алдартай анчин Хорлоо, мөн Нэмэндий гуай нар бусад олон анчид цөм ярьдаг нь үнэнтэй баталгаа мөн. Тэр учраас энэ гахайн дөрвөн хөлийг шулуухнаар зурсан болов уу. Энэ хөшөөний эзэн хүн нь тухайн үедээ нийгэмдээ тус ачтай алдар цуутай анчин байсан учир түүний гавьяаг мөнхжүүлэх зорилгоор эрхлэн хийж байсан ажил хөдөлмөрийн бодит байдлыг зориуд тусган тэмдэглэж зурсан байх болов уу. Үүнийг отог овгийн удирдагч биш гэж ангийн хувьд түүний ялгаврыг үгүйсгэж байгаа хэрэг огт биш заавал ноёлох ангийн хөшөө байх ёстой биш, олондоо алдаршсан ан агнуурын удирдагч багш нь байж болно шүү дээ. Зангыг эзэмшсэн туршлагатай анчин хүн тухайн үе бүрийд үнэ хүндтэй байсан нь мэдээж билээ.

Д. Чандага ба хүдэрийн занга. Эдгээр амьтны хүч чадал бага байдлыг харгалзаж нарийвтар [fol. 4 verso] модыг унагаахдаа хожуулыг метр хиртэй өндөр үлдээж унагаасан модны бөгсөн талаас 2 м тайрч аваад хожуулд тулган босго болгон зоож тавиад нөгөө үлдсэн үзүүр талын доод талын гишүүг зулж бусад яр гишүүг авахгүйгээр урагш нь чирч хожуулдаа арай зайтай нөгөө босго дээр унахаар бодож хөшүүргээр хожуул дээгүүр өндийлгөн түүний үзүүрээс бат бэх зүйлээр оосорлож оосорны үзүүрт тэвх уяж түүнийгээ тусгай модонд чагталж тэр тэвхээс өвлийн цагт бол цагаан хялгасаар ангийн явах замыг хөндлөн татаж тавих бөгөөд орж байгаа анг цээж хавиар нь дарахаар тавина. Энэхүү занга нь бусад дээр дурдсан занганы нэгэн адил үйлчилгээтэй учир тэр бүрийг давхардуулан бичих хэрэггүй гэж үзлээ. Чандаган занга бол хүдрийн занганаас хөнгөн байх болно. Харин жижиг биетэй хурдан хөдөлгөөнтэй амьтан тул маш түргэн унах занга тавина.

Е. Саравчин занга. Энэ зангыг тавихдаа 5-10 ширхэг гуалинг нарийн үзүүрийг газарт нь, нөгөө бүдүүн үзүүр буюу гуалингийн бөгсөн талын үзүүрийг ан багтах зайтай сөхөж тэдгээр моднуудаа зэрэгцүүлэн хавчиж тавьдаг байна.

Ийм занга бол нэг буюу хоёр анг зэрэг дарахаар бодож зохион байгуулсан байна. Харин муу тал нь гэвэл ийм саравч аятай нүсэр өргөн занганаас ан амьтан айж сэжиглээд доогуур нь явахгүй эргэж буцаад байдаг тул манай нутагт удаан байж чадаагүй бололтой.

Үүний тэвхийг дээр нь юмуу дор нь хийж ангийн хөл нурууны аль нэгээр шүргэхэд буухаар хийсэн байдаг гэнэ. Эртний жинхэнэ занганы үлдэгдэл одоо хүртэл хадгалагдан үлдээгүй боловч хойно хожим тавьж байсан модон занга Хэнтийн нурууны олон газар дээр дурдсан хэлбэрийн [fol. 5 recto] зангануудын илжирсэн үлдэгдэл энд тэнд тохиолддог гэж Хэнтийд олон онд ан хийж явсан Легдэн овогтой Самдан, Ринчин нар ба бусад анчид ярьж байгаа нь эртний занга биш боловч түүний уламжлалаар ардын хувьсгалаас өмнөхөн тавьж байсан зангануудын үлдэгдэл болох юм. Ер нь зангыг цаашид үргэлжлүүлэн судлавал үүнээс өөр өөр занга буюу түүний тавих зүүх аргууд нь олдож болох юм.

Ё. *Хашаан занга (Хориг)*. Хашаан хоригийг ганцхан чононд зориулж тавьдаг учир үүнийг чоно элбэгтэй чонын гүйдэлтэй газарт барина. Идшинд гөрөөлж яваа олон чоно бүгдээрээ хашаанд ороход хаалганы тэвх мултарч гарах нүх сүвгүй болдог. Ийм занга нь 3,5 м босоо шургааг буюу тал дүнгээр дугуй хэлбэртэй хашааг доод талыг газарт суулган нугасан холбоогоор хооронд нь хэлхэж хоёр давхар хашааг хоорондуураа 40 см зайтайгаар гудамж эргэн тойрон гаргаж барина. Дотуур хашааны дотор өвс тэжээлтэй ямааг хашиж бас мах өлгөж орхино. Ил махан дээр хэрээ шувуу өдөржин бужигнах учир алсаас чоно мэдэж ямар нэгэн идэш бий болсон газар хэрээ шувуу бужигнадаг тул чоно эрхгүй заавал ирдэг. Гэтэл дотор нь ямаа ч байгаа учир гадна хашааны дутуу онгойсон бие багтах нарийн хаалгаар түрүүчийн чоно орж дараагийн чононууд даган цувсаар нарийн дугуй гудамжаар явсаар дутуу онгойлгож тэвхэн сойлттой байгаа хаалга хүрч ирэхэд оньс нь мултарч хаалга тавхийн хаагдаж түгжигдэнэ. Хашаа өндөр, зай давчуу, бас ч дугуй хэлбэртэй учир харайж

гарч чадахгүй олон чоно хойно хойноосоо цувран яваа учир ухрах буюу эргэж болохгүйгээс урдах нь явж хойдох нь дагасаар хоёр хашааны завсарт агнах хүн иртэл явсаар хашаагаа мэрэх боловч төдий л гэм хүргэж чадахгүй байдаг байна.

Хүмүүс энэхүү занга барьж дуусаад явахын өмнө хэлдэг [fol. 5 recto] үгтэй байжээ: “Хангай дэлхийн хайр хишиг, хадар соёо шүдтэй, хар сортой халуун саарал чоноор, хашаа хоригий минь ханатал дүүргэж соёрхоо” гэж дөрвөн зүгт цай сацаж “Орсон олз арвин дээр, оньс мултар” гэж хэлээд тэвхээ сойдог байжээ. Анчин Зөрүү хэмээх Доржийн үг юмаа.

1923 онд манайх Тэрэлжийн Шар дэвсэг газар өвөлжсөн тэр өвөл манай айл өвөлжсөн айлуудын дунд Хэрэмчин Жамьян хэмээх шинэ залуу анчин байлаа. Би түүнийг дагаж өдөр бүр хол ойр хэрэм агнахыг сурах санаатай явдаг байлаа. Ингэж явахдаа Бага Мухарын модон дотор ойр хавийг томог тавьж хаасан зангыг нүдээр үзэж тэр үед юу болохыг мэдэхгүй Жамьянгаас асуусанд, занга гэдэг юм гэж анх удаа мэдэж авсан юм. Ингээд зангыг хэрхэн тавьдаг, энэ занга ямар анд тавьсан зэргийг бүрэн мэдэх болсон. Харин энэ занга он удсан учир мод нь илжирсэн байсан юм. Дараа өвөл нь Хойд Сайханд байхад хөвчийн алдартай анчин Зөрүү Дорж, Дэндэв нар миний ах Шаравтай анд гарахаар манайд ирж ангийн тухай урьдын нэртэй сайн анчдын тухай өөрөө Заанд занга тавьж байсан зэргээс сонсоход миний үзсэн занга зэргийг оролцуулж байв. Би тэр үед бага байсан учир тэдний ярианд орох байтугай асуух ч эрх зэрэгт хүрээгүй байлаа. Харин занганы тухай, тавих ёс, хэлэх үг зэргийг онц сонирхож билээ. Шүлэг маягтай үг болохоор хүүхэд багачууд тогтоож ярьдаг байсан юм.

[fol. 6 recto] *Чонын хориг занга*. Өндрөөрөө 1 м орчим хэмжээтэй хааш хаашаа 7 м хиртэй зайтай дугуй хэлбэртэй хашаа барьж хашааныхаа төв дунд нь гүнээрээ 3 м дугуй нүхийг гадуур хашаанаасаа 1,5 м дотуур малтаж энэхүү намхан дугуй хашааныхаа толгой дээрээс нөгөө 3 м нүхнийхээ амсар луу 0,3 м хиртэй өнгийлгөж сайн харуулдаж

өнгөлсөн банзаар тойруулан ташуу байдлаар уруудуулан битүү хучаад өнгийж үзэхэд дотор талын хэлбэр төрх нь конус буюу цорго шиг дугуй ташуу гүн хонхор луу юу ч тогтохгүй гулсаж орохоос биш орсон амьтан буцаж гарна гэх найдваргүй болдог байна.

Гадуур хашаа, дотуур ташуу хучлага хоёрын хооронд дулаан хэвтэр тэжээлтэй ямааг тусгай хаалгаар оруулж орхидог байна. Ойр хавь нь хүн амьтангүй болохоор ямаа хааяа хааяа майлах буюу ялангуяа ямар нэгэн амьтны чимээ авахаар майлах нь бүүр ч илүүтэй болдог. Үүний чимээ үнэр авсан өлөн чононууд эрхгүй хашааны дэргэд хүрч ирээд хашааны дотор мал байгааг мэдэж эргэн тойрон шиншлэхэд чонын үнэр авсан ямаа айж дугуй хашаагаа завсраар нь тойрон давхих тул үүнийг барьж идэх гэсэн чононууд тэсч ядахдаа ямааг барьж идэхээр шууд хашаан дээгүүр харайж ордог.

Ер нь хашаатай хонинд чоно хашаан дээгүүр нь харайж ороод дотор нь сүйтгэдэг амьтан бөгөөд [fol. 7 recto] гэхдээ чоно нь онц хардамтгай амьтан тул хашаан дээгүүр орохдоо аль намхан сэжиггүй газраар биеэ хашаанд хүргэхгүй хий үсрэн давдаг тул тэр ёсоор ийм хашаан дээгүүр нэгэнт харайсан хойно биеэ татаж авах нөхцөлгүйгээр ташуу банзны доод үзүүр дээр буунгуут тэр дороо гулсаж нүхний ёроолд унадаг байна. Хэдэн чоно байна, ийм хашаан дээгүүр бие биеийн хойноос цувран харайсаар бүгдээрээ ордог байна.

Ийм хашаан хоригийг чонын тогтмол гүйдэлтэй газар юм уу, ялангуяа чонын от цуглааны үеэр чоно нэлээд цуглах зэлүүдүү газар зохион байгуулсан байхад сүрэг чонотой байх явдал ч байдаг байна.

Ийнхүү хоригт орсон чононууд ульж бие биедээ мэдээ чимээ өгдөг учир ойр хавийн чоно цугларч олз нэмэгдэх тал байдаг байна. Давчуу нүхэнд олон чоно орж шахцалдан уурандаа бие биеэ барьдаг байна. Нэгд, отны үе гичийгээ булаалдах, хоёрт, хоригт орсон зэрэгтээ уурлаж бие биенээ барьдаг. Гуравт, эдгээр чоно нь нэг эхийн биш, газар газраас цугларсан сүрэг тул аль чадалтай нь чадалгүйгээ барьсаар дуусдаг байна.

Ийм аргыг Лэгдэн овогтой анчин Самдан мэдэх тул ярьж өглөө. Чоно элбэгтэй хангай нутагт дээр үед хэрэглэж байжээ.

[fol. 8 recto] *Шор, жадтай занга.* Шортой занга, жадтай занга, сөрлүүрт занга гэж байсан гэж 1930 онд Хөвсгөл аймгийн харьяат аль сумынхы нь мэдэхгүй өвгөн анчин Томой гуай надад ярьсан юм. 1926 онд Амгаланбаатарт Цагдан сэргийлэхийн цагдаа байсан Баавгай хэмээх Гэндэн, мөн цагдаа Алтангэрэл нар хоорондоо ярилцаж байсан нь Булган аймгийн Хантай уулнаас Зөвлөлтийн хил орчим ийм занга хэрэглэж байсан тухай тус тус ярьсан. Харин өөр мэдмээр хүн тохиолдохгүй байна.

Энэ гурван занга нь хоорондоо бараг адил учир газар газар өөр өөр нэрлэдэгээс болж ийм гурван өөр нэр бага зэрэг ялгаатай байгаа болов уу. Энэхүү нэвт шувт сүлбэдэг зэвсэг хавсарсан зангыг ихэвчлэн баавгайн агнуурт зориулж тавьж байсан гэдэг юм.

Ийм зангануудыг тавихдаа хажуу тийшээ мод налан унасан буюу бөхийсөн мод шиг болгож дүүжин тогтууртай тавьж шор жаднуудыг доош харуулан зоож түүнийгээ шилмүүсээр хучиж далдлан өнгөлж тавина. Тавихдаа бусад зангануудын нэгэн адил ангийн яг цувлан зөрөг дээр нарийн зүүж зөв байрлуулж тавьсан байхад тэр зөргөөр нааш цааш явах ангууд нь төдий л сэжиг авч тойрч дайжихгүй хэвийн байдлаар урагшлан явсаар ордог байна.

Ер нь ийм зангыг гол төлөв зөргөөс гадуур гарах боломжгүй үхэр асга дундуур буюу хад хясаа боосон зөвхөн завсар чөлөөгөөр нь явдаг нарийн зөрөг дээр ихэвчлэн буюу хэрвээ салаа зөрөг байвал ийм хэд хэдэн занга тавьдаг байна. Анхны ан ороход түүнээс зайлж нөгөө занганд ордог гэнэ. Занганы босгыг ан алхаад ангийн хөл буюу хэнхдэг цээжийн аль нэгэн хүрмэгц сойлт утас нь татагдаж тэвхэн торомж нь мултрахаар тавьдаг байна.

Яг энэ үед ангийн нуруун дээр өөрийн жингийн хүндийн эрчээр гэнэт буух гуалинд доргогш нь [fol. 8 verso] харуулан зоосон хэд хэдэн шорлох хурц шовх үзүүртэй ямар нэг

төрлийн шор буюу жаднуудыг бахим байдалтайгаар байрлуулсан байдаг байна.

Ийм занганы дарах цохих нуруу гуалин нь дорогш унахдаа ангийн биеийн аль нэг эгзэгтэй хэсэгт шорлон шаахаар тохируулж тавьсан байна. Үүнд, ангийн аль нэг хэсэгт хүнд шарх гэмтэл өгдөг байна. Нэгэнт шархадсан ан нь тэр дороо үхэх буюу хөнгөн занганаас мултарлаа ч гэсэн төдий л холдож чаддаггүй үхдэг байна.

Зангыг төрөл бүрийн ан гөрөөс элбэгтэй ой хөвчид ан тус бүрийн онцлогт тохируулан тавих боловч зарим арын мод нь шинэчлэгдэн ургаж байгаа залуу зулзаган буюу шургааган голдуу ойтой байхад зарим ой нь хэтэрхий бүдүүн модтой гэх зэрэг харилцан адилгүй модтой газар зангыг тавихдаа занганы гол ноён нуруунд энэхүү сүлбэх зэвсэг давхар хэрэглэх нь ан агнуурын хөдөлмөрт бүтээмжийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл, ангийн олз ашиг ихтэй байхад зохих хэмжээний нөлөө үзүүлдэг нь эргэлзээгүй байна.

Ийм аргаар эрт дээр цагт агнадаг байсан тухай зарим мэдэх анчдын домог ярианаас үзэхэд энэхүү сүлбээрт зангыг бусад зангануудын нэгэн адил манай оронд тухайлбал, ойн иргэдэд өргөн хэрэглэгдэж байгаад бусад төрлийн зангануудын нэгэн адил хориглогдох буюу ан агнуурын зэвсэг багажийн хөгжлөөс хоцрогдож хаягдсан байх учиртай болов уу.

Ер нь занга сайль мэт [fol. 9 recto] хүн малд аюултай зэвсэг багаж хэрэглэхийг бүүр 13-14-р зуунаас хориглож эхэлсэн ба улсаас ангийн хууль анх тогтоож дагаж шийтгүүлсэн нь аливаа нэгэн занга сайль гэх мэт аюултай зэвсэг дэлгэрч хэрэглэх нь бууран буурсаар сүүл сүүлдээ бүрмөсөн хэрэглэхээ больсноос сүүлийн үеийн анчид зарим төрлийн занга нь зөвхөн домог төдий үлдэж зарим нь мэдэх баримтгүй болжээ.

Байшин занга (Хориг). Төрөл бүрийн ан элбэгтэй газруудад дүнз гуалингаар дөрвөн булангий нь зааж модон хадаасаар холбож барьсан пүнзний дээвэр оройг гэрэл гэгээтэй байлгахын тулд хагас буюу бүтэн задгайгаар барьж гадаа үүднээс эхлэн дотор нь өвс хужир

тавьсан байхад гадуур ирж дассаар ганц хоёр өвс марааг долоож байсан бол сүүл сүүлдээ бүүр олноороо ирэх болж байшин дотор байгаа өвс хужраас идэхээр ордог байна.

Хэрвээ гахай, баавгайд зориулах юм бол гадуур нь яс махны зүйл хаяж дотор нь мөн мах яс, үр будаа, төмс зэрэг тэдний идэх дуртай зүйлийг хийж орхиход баавгай, ялангуяа гахай байшинд ордог байна. Баавгай авирч гардаг амьтан тул орой гэгээвчийг дээврийн голд нь гаргадаг гэнэ. Хаалга нь дотор талдаа сойлт тэвхтэй байх учир гэнэт хаагдаж түгжигдэн хаадаг байна. Үүний тулд заавал хурдан хаагдах нуман өшиглүүр байдаг байна.

Ер нь хаалгатай занга бүр ийм зохион байгуулалттай хийгдсэн байдаг бөгөөд дотор нь орсон амьтан гарах нөхцөлгүй болдог байна. Үүнээс үзэхэд, эртний хүмүүс ийм аргаар аливаа амьтныг амьдаар барьж авах буюу агнадаг байжээ.

Ийм зангыг чулуун зэвсгийн үед ч хэрэглэж болох юм. Унанги дархи модыг тэр хэвээр нь буланг заахгүй хашаа шиг зөрүүлэн тавьж бариад гарын малыг хүртэл барьж байсан байж болох юм. Ингэж байсан гэх баримтгүй тул батлах үндэс одоодоо үгүй байна. Ийм занга үргэлжид ангаар гол болгон амьдарч байсан хүмүүс ан амьтдыг агуй хавцалд [fol. 9 verso] хорьж хашиж үзсэн туршлагаас үүсэж анхандаа бүдүүлэг хийж байснаа сүүлдээ хөгжүүлэн ирсэн нь лавтай болов уу. Ийм зангыг Хэнтий, Хөвсгөлийн зэлүүд ой тайгад хэрэглэж байсан гэдгийг зангын тухай ярьж байсан дээрх анчид ярьж байсан юм.

Томог буюу ходгоод. Томогт занга буюу авлалт нь ангийн байрших газрын ойролцоо дамжин гүйх замын дагууд модоор нэлээд газрыг хамран барина. Ангийн орох амыг барагцаалвал 500 м буюу 1 км хиртэй өргөн барьж явах тутмаа нарийсч мухар руугаа ходгоод шиг нарийн болж мухардана.

Хадны зургаас үзвэл ам нь ¼ -тэй тэнцэх өргөн бөгөөд яг малын ходоод хэлбэртэй юм. Энэ хуучин анчдын ярьж байсантай ойролцоо байна. Ходоодон томогны үүдэн талын томог нь нэг дан модоор төдий л өндөр биш барьж

мухар тийшээ хоёроос гурван мод давхарлан өндөрлөж орсон ан доогуур буюу завсраар шургаж болохгүй ба бас дээгүүр нь харайж гарах боломж өгөхгүйгээр тохируулж барьсан байдаг байна.

Ходоодон томогт анг олны хүчээр хоморголон хөөж оруулах бөгөөд хагас хүмүүс нь үүд талыг хамгаалж байхад зарим нь дотор нь орж мухрын нарийн уруу хөөн оруулаад үүдийг модоор хааж буцаж гарахгүй болгодог байна.

Үүний баримт нь анчин Төмис [?] нарын ярианаас гадна, археологич эрдэмтэн Н.Сэр-Оджаваас “Шинжлэх Ухааны Академийн мэдээ” сэтгүүлийн 1968 оны №3-ын 57-р хуудсанд Увс аймгийн Хархираа голын савд Халхайтын хүрэн үзүүр гэдэг газрын хадан дээрх зураг дотроос ходоодон томогны талаар “... хэдэн янгир бугыг хорго татаж авлаж байгаа [fol.10 recto] сийлбэр байна. Амьтдыг хар хурдаар нь хөөн оруулахад зарим нь хоргонд тулж очсоноо аюуж мэгдэн эргэн зугтааж байгаа байдлыг чадмаг сийлжээ” гэж бичсэн байна [Зураг].

Үүнийг зарим газар томогт занга, ходоодон томог, зарим газар томогт ав гэж нэрлэж байсан бололтой, үүнтэй ойролцоо аргаар манай Бугын Сангийн Аж Ахуй бугануудаа гартаа оруулж байдаг байна. Харин зүүн Сибир Буриад нутагт дэлгэрч байсан зээгт ав бол улаан даавуу зэлээр томог татан хүрээлж анг хөөж оруулах арга бол модон томог буюу олон хүний хүчээр бүслэн хоморголох явдлаас үүсэлтэй хүний хүчийг хэмнэсэн явдал бөгөөд анг нэг газраар цутган гарахад нь эрт цагт бол харвах, сүүлдээ буудаж агнахын аль алинд ашигтай арга бөгөөд зэл бол хурааж аваад дахин өөр газар татаж болох хөнгөн хялбарчилсан хэлбэр юм.

Харин модон томог бол байнга ан хийдэг, түүгээр амьдардаг овгийн ажил бөгөөд сүүл сүүлдээ хүмүүсийн амьдарлаг олон талаар сайжран, ангийн багаж зэвсэг сайжирч, мал аж ахуй ноёлох суурь эзлэж ирэхээр нүсэр хөдөлмөр зарцуулах ийм арга хэрэгсэл хоцорч хаягдсан байна. Ингээд зөвхөн яриа домог төдий үлджээ.

[fol. 10 verso] *Хөмрөг занга*. Хөмрөг буюу өмсгөл зангыг үнэг буюу жижиг амьтад, ялангуяа булганд хэрэглэж байсан төрөл зангын төрөл багтана. Ийм зангыг жижиг махчин амьтанд тавихаас гадна том, дунд ан амьтанд тавьдаг байжээ. Ийм зангыг ангийн зайлшгүй явдаг зөрөгт тавихдаа ан тогтмол явдаг замаа өөрчлөн гадуур явах боломжгүй үхэр асгууд дундуур хоорондуур гарсан зөрөг цувлан буюу хад хясааны завсар ёроолоор ганц ганцаар цувж гарахаас өөр боломж муутай нарийн жим дээр тохиромжтой газрыг шилэн олж энэхүү өмсгөл зангаа байрлуулан тавьдаг байна.

Ийм өмсгөл занганд орсон амьтан бараг гэмтэлгүй дотор нь хоригдож байдаг байна. Ийм зангыг ой хөвч ихтэй Хэнтий ба Хөвсгөлийн ууланд эрт цагт хэрэглэж байсан юм гэнэ билээ гэдэг домог яриа үлдсэн байна. Ерөө голын сав Шарлан Хонь нугаар нутаглаж байсан Хамниган анчдын өвөг нар тавьж байсан тухай 1929 онд Амгалангийн 6-р хорооны дарга байсан Хамниган Адьяа тэр үед ярьж байсан юм. Манай өвөг эцгээс урьд барагцаалбал, 200-300 жилийн өмнө өмсгөл зангыг Ерөө голын эх өөд тавьж байсан юм гэдэг гэж ярихын хамт энэ занга нь байшингийн орой шиг шовгор, гурвалжин буюу дөрвөлжин авдар чингэлэг хэлбэртэй томхон юм байсан гэдэг. Занганы хүрээ яс мод нь том анд бол нэлээд бүдүүн нойтон гуалин дүнзийг хөлгөж зангидаад түүндээ нарийвтар нойтон модоор сараалж хөндөл яс модонд нь хэрж баг бэх углуургадаж бэлтгээд тусгай хөшүүргэн тэвхээр ямар төрлийн ан байна, түүний өндрийн хэмжээнд тохируулан нэг талыг нь өндийлгөн тэвхдэж тавьдаг байна. Энэхүү занга нь нэлээд өргөн учир доогуур нь ан амьтан сэжиггүй орох боломжийг хангахын тулд занганы хоёр талыг халхлах зорилгоор шилмүүстэй мод торлог босгон тавьдаг гэнэ. Ингэж сайн өнгөлөн далдалсан занганы доогуур ан ажиг сэжиг багатай явахад ангийн хөл буюу [fol. 11 recto] биенд тэвхний нарийн татуур хүрч тэвх нь мултармагц ангийн дээрээс өмсөн буухдаа хүндийн эрчээр түргэн зуур унадаг тул доор нь орсон ан амьтан гэнэт ухасхийх боловч гарч чадалгүй хөмрүүлэх

буюу заавал хүрээ модонд цохиулж унадаг байна. Ийнхүү дотор нь орсон буга гөрөөс зэрэг ан зангаа өргөж гарах боломжгүй өндрөвтөр, мөн чирж явах аргагүй дотор нь амьд байх тул барьж авахад бүрэн боломжтой байдаг юм байна.

Жишээ нь, хэрээс модны нь завсраар ан амьтнаа оосорлох буюу хүлж байхад тохиромжтой нөхцлөөр хангагдсан байдаг байна. Ийм зангыг гэр сууцнаасаа зайдуу зэлүүд газар аль ч улиралд тавих учир очиж эргэхэд хэрвээ зуны улирал болж байлаа гэхэд мах нь ялзарна, өвөлд хөлдөж авч болохгүй гэх юмгүй юм. Үүнээс үзэхэд, эртний хүмүүс ямар нэг төрлийн анг амьдаар нь барьж авчраад гарын мал болгоход ашиглаж байсан байж болох юм. Ийнхүү тавьж бэлтгэсэн зангандаа анг оруулахын тулд ойр хавийн анг зориуд үргээх журмаар оруулах ба ерийн урсгал байдлаар ангууд орж болох олон талтай юм.

“Монголын хүрлийн үе” номонд археологич эрдэмтэн Сэр-Оджавын олж нээж бичсэн 55-р хуудасны 6-р зургуудын дотор байгаа энэ зургийг эргэцүүлэн үзэхэд өмсгөл занга баймаар байна [Зураг]. Энэ зургийн дүрс хэлбэр дээр дурдсантай яг нийлж байгаа тул энэхүү хөшөөний эзэн ийм аргаар агнуур хийж байсан байж болох юм. Бусад зургуудыг тохирох газрууд нь жишээ болгосон учир энд дахин үзүүлсэнгүй болно.

[fol. 1) recto] *Хавчирган*. Эртний хүмүүсийн амьдарлагад аливаа ан агнуур гол үүрэг гүйцэтгэж байсан цаг бий учир түүхийн урт удаан хугацааны явцад янз бүрийн олон шинэ шинэ арга хэрэгслүүд бий болсоор байжээ. Үүний дотроос аль илүү үр дүнтэй нь шалгарч үлдээд удаан хугацааны дунд сайжрагдан хэрэглэгдэж тухайн үе шат бүрийд үүргээ үр ашигтайгаар өгсөөр иржээ.

Эрт дээр цагаас манай оронд хэрэглэгдэж байсан агнуурын олон төрлийн багаж зэвсгүүдийн нэгэн нь болж байсан энэхүү хавчирган гэдэг багаж нь одоогийн төмөр хавхны өвөг бололтой юм. Хавх гэдэг нь хавчих буюу хав гэж гэнэт нохой шиг зуух гэсэн утгатай үг тул энэ модон хавчраг буюу хавчирган нь мөн л хавчих гэсэн утгатай

байгаа тул нэг төрлийн зэвсэг байна. Харин хавчирган нь модоор хийгдсэн зэвсэг учир хэлбэрийн хувьд яг төмөр хавхтай адил биш боловч үйлчилгээний хувьд төмөр хавхтай ойр төстэй юм.

Энэхүү эртний хавхыг модоор хийж байсны хувьд хялбархан бүтээж болмоор мэт санагдавч хэн хүн барьж авсаар хийж чадахааргүй өөртөө онцлог нарийн зохион байгуулалттай учир тэр үеийн анчид бүр үүнийгээ хийж чаддаг байсан юм уу, эсвэл агнуурын төрөл бүрийн багаж зэвсгийг дагнан хийх ажилд тусгай мэргэжсэн хүмүүсээс бүрдсэн жижиг үйлдвэрийн чанартай газар байсан биз. Жишээ нь, эртний чулуун зэвсгийг хүртэл тогтмолдуу нэг газар үйлдвэрлэн байсан эртний хүмүүсийн бууц сууцыг дэлхийн олон эрдэмтэд ялангуяа манай археологич эрдэмтдээс сүүлийн жилүүдэд олныг олж нээж судалсан ховор чухал нээлтнээс үзэхэд дээрх дүгнэлтэд хүрч болох байна.

Хавчирганы амсар буюу орой талыг том жижиг хоёр дугуй цагариган хүрээг дээд доод хоёр талд нь сөөлжүү янзаар угсарсан байдалтайгаар тохируулж түүндээ эргэн тойронгоос нь үзүүрий нь дотогшоо харсан хурц ирмэг үзүүртэй олон хуруунуудыг хооронд нь бараг зайгүй [fol. 1) verso] шахам зэрэгцүүлэн тавиад эдгээр хуруу шоруудыг бөгсийг нөгөө гадуур хүрээ цагаригны (нуруу) буюу дээд талд нь тусгай тохируулан гаргасан хэрчлээс торомж ба уяа зэргээр холбож бэхэлсний дараа хуруудын дээр нь гараар дарахад доргогшоо уян налархай бөхийж гараа авахад пүрштэй юм шиг тусгай өшиглүүр буюу хуруунуудын бөгсөнд тохируулан зүүсэн дүүжин чулуу зэргийн хүчинд буцаж байрандаа очиж байхаар зохион байгуулж хийдэг байна.

Харин бага дугуй цагирагийг том дугуй цагаригнаас арай дотогш байхаар тохируулан бэлтгээд хуруу шоруудын нуруун дээр доод ул том цагаригны хэрээс модонд дөрвөн урт тулгуур шонгоор шууд холбоод бас дээд том цагаригтай дөрвөн тийш нь татуурган холбоогоор тус тус бэхэлдэг байна. Энэхүү бага цагаригны үүрэг нь орсон ангийн хөлийг

хавчсан хуруунуудыг хэвийн хэмжээнд дарж тогтоож байх үүрэгтэй байна. Хэрвээ ийм зохион байгуулалтгүй бол хавчирганы хуруунууд ангийн хөлөөр сөхөгдөн задрах учир орсон ангаа тогтоож чадахгүйд хүрнэ. Түүний гол учир нь гэвэл хавчирганы хуруунуудын дээр ангийн хөл гишгэхэд дорогшоо хялбархан бөхийж нөгөө зайгүй шахам зэрэгцүүлэн бэхэлсэн хуруунуудын завсраар сарзайсан зай завсрууд гарч үүгээр ангийн нарийхан хөл орохоор бодож зохион бүтээсэн байдаг байна [Зураг].

Ийнхүү хавчирганы хуруунууд ангийн хөлийг хавчиж барьдаг тул хавчирганыг ангийн хөлд зүүгдэн явуулахгүйн тулд хавчирганы дээд цагаригийг бодоход арай том цагаригаар доод талд нь [fol. 2) recto] суурь хийнэ. Хавчирган нь дээд цагаригнаас ул цагариг хүртэл барагцаалбал 80 см хиртэй өндөр, дээд талын цагаригны дундах талбай хааш хаашаа 1 м байх бөгөөд хуруунуудын өргөн нь дунджаар 5 см-ээс онц илүүгүй байна.

Харин хуруунуудын дээд нурууг гурвалжин буюу бөөрөнхийгөөр засаж ширхэг шулуун, яргүй хус модоор хийнэ. Гэхдээ модоо битүү хатаана. Хуруунуудын зузаан нь 7 см хиртэй байхаар тохируулна. Хуруунуудын урт нь гадуур цагаригнаас дотогш 50 см байдаг. Дээд бага цагаригнаас доод суурийн том хүрээ цагаригны дөрвөн хэрээс хөндөлтэй дөрвөн татуурга шонгоор бат бэх холбож ангийн хөлөөр хуруунууд өөдөө сөхөгдөн задарч ангаа алдахаас хамгаална. Харин дээд том гадуур цагаригнаас суурь цагаригтай шууд дөрвөн тулгуураар холбож дотор нь шороо чулуу нурж орохоос хамгаалж гадуур нь арьс ширээр бүрдэг байна.

Ангийн хөлөөр дорогш орсон хуруунуудаа өөдөө босож хэвийн байдалд орохын тулд хуруунуудын илүү гарсан бөгсөнд таван хуруу тутмын бөгсийг дорогш нь дарж байхаар тасархай цагаригнуудаас 3 кг орчим хүндтэй чулуу дүүжилж тавьдаг байна. Энэ учраас хавчирганы хуруун дээр ангийн хөл гишгэхэд зөвхөн тэр хэсэг нь цөмрөхөд бусад хэсгүүд нь хэвийн байдалтай байхаар

зохиогдсон байдаг байна. Хэрвээ хоёр хэсэг таван хурууны зааг дээр онож гишгэх юм бол 6 кг баримжаатай хүнд дүүжинтэй хэсэг цөмрөх жишээтэй байна.

Хавчирганыг тавихдаа газрын өнгөн хөрстэй тэгш байхаар газрыг ухаж суулгана. Ийнхүү хавчирганд тохируулан дугуй хонхойлгон малтаж суулгасан учир торох тээглэх юмгүй амархан цөмөрч сарзайж гарсан завсраар ангийн [fol.2) verso] хөл ороод буцааж татахад нь хуруунууд нь хоорондоо шахцалдаж улам чангаран хавчдаг байна. Гэвч онгон зэрлэг ангийн нэг хөлд орсон модон хавчирганыг ан амархан эвдэж магадгүй тул орсон ан сочсондоо учир зүггүй туйлахдаа өргөн талбайтай тэр хавчирганд дахин өөр хөл нь ордог. Эсвэл ойр зэрэгцүүлж тавьсан өөр хавчирганд орж тэлэгдэн энэ бүгдээс салж чадахгүй савж унаад хөлөө мултлах буюу хугалдагаас хүнд гэмтэлд орж босож чадахгүй хүч тамираа бардаг байна.

Хавчирганыг зээрийн усанд ордог цувлан жим дээр буюу нуур тойрмын захаар ойр ойрхон зайтай тавьдаг байна. Чоно үнэгэнд тавихад найдвартай ордог боловч орсон ангаа тэр даруйд нь гаргаж авахгүй бол модон хавчирганаа тас хэмлэж сулардаг байна. Үүний тулд чоно үнэгний гүйдэл үеэр ан амьтны сэг яс зэрэг эргэлдэх зүйлийн дэргэд тавьж орох ёстой цаг үеийг барагцаалан ойр орчим нь нүхэн нууцанд нуугдаж байгаад орохтой зэрэг очиж авдаг байна.

Энэхүү хавчирган гэдгийг металл багаж зэвсэг бий болсноос хойно модыг багажаар засаж чаддаг болсон цагт хийж хэрэглэх болсон болов уу. Гэвч энэ тухай биет материал хараахан олдоогүй байна. Сүүлд бий болсон төмөр хавх нь дугуй хэлбэртэй цагирагаас бүтсэн байх нь эртний энэхүү модон хавчирган гэдэг нэг ёсны хавхнаас үндэслэлтэй болох нь гарцаагүй бололтой байна.

[fol. 8) recto] *Хананга*. Хананга ба хавчирган гэдэг хоёр өөр төрлийн багажийг агнуурт эрт дээр үед манай оронд хэрэглэж байжээ. Энэхүү багаж зэвсэг нь агнуурт тавьж хэрэглэх өөр өөрийн арга зохион байгуулалттай юм. Үүнийг Монголын

дорнодын тал нутагт бол голчлон цагаан гөрөөс, чоно зэрэг анг агнахад өргөн хэрэглэж байсан нь одоогоор тодорхой мэдэгдэж байна.

Энэ тухай тэр нутагт домог ярианы үлдэгдэл одоо хүртэл байгаа нь иймэрхүү арга хэрэгслийг энд бусад газрыг бодоход нэлээд хожим болтол агнуурт хэрэглэж байсан болов уу гэмээр байна. Үүнийг Гоц Халдвартаас Сэргийлэх Станцын амьтан судлалын эрдэм шинжилгээний ажилтан Жигмэд овогтой Дэмбэрэл өөрийн байгууллагын төлөвлөгөөт хайгуул шинжилгээний ажлаар 1968 онд Дорнодын тал нутгаар явж гоц халдвар дамжуулж болох амьтанд судалгаа шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэжээ.

Ингэж орон нутагт ажлаар явах бүрдээ орон нутгийн ардуудын дунд хэрэглэж байгаа юмуу, эрт урьд хэрэглэж байгаад зөвхөн яриа домогт үлдсэн эртний агнуурын арга хэрэгслийг олж мэдэх, үүгээрээ өөрийн мэргэжлийн ажилд цаашид тус дөхмийг өгч болмоор эртний агнуурын аргуудыг голчлон сурвалжилж мэдээ материал цуглуулсаар ирсэн байна. Тухайлбал, судалгаа шинжилгээний холбогдол бүхий хэрэгцээт ан амьтдыг амьдаар нь барихад боломжтой хуучны агнуурын ямар ямар аргуудыг орчин үеийн нөхцөлд тохируулан хэрэглэж болох талаар сонирхож мэдээ материал сурвалжилж байснаас Дорнод аймгийн Матад сумын зарим ахмад анчдын мэдэж байгаа эртний агнуурын багаж зэвсэг түүнийг хэрэглэх тухай домог ярианаас сонсоход манай Дорнод Монголын үржил шимтэй өргөн уудам тал нутаг маань хэзээний өвс ургамал ихтэй, ан амьтнаар [fol. 8) verso] баялаг, чухам хүн амьтны дур сэтгэлийг татсан амьдралын нөхцөл олон талаараа бүрдсэн ёстой сайхан нутаг билээ.

Анчдын хэлдэг үгнээс оруулан ярьсан нь: “Манахан тэнгэр минь, магнай дээр минь цэлийлсэн мянга мянган намрын улирал ирэхэд ногооны шим шүүс татарч сөл буурч өвс хагдарч ирэхэд Мэнэнгийн өргөн тал, Лаа [?] вангийн урт цайдам хоолойд хааяа хааяа тохиолдох нуур тойром бүрдүүдийг бараадаж ангаж цангаж байгаа ан амьтад усандаа ойртон ойртсоор сүүл сүүлдээ зээрийн олон сүрэг мянга мянгаараа зай чөлөөгүй нуур руу

тал бүрээс нь цутган орж гарч байдаг юм. Энэ үе нь зээр гөрөөсний тарга гүйцэж үнэг чонын үс ноолуур нь сайжирч ирдэг тул ханангыг нуурын захаар буюу ангийн усанд орох гарах зам зөргийг тосгон тавьдаг” гэжээ.

Ханангыг ийнхүү тавихдаа хааш хаашаа хоёр метрийн хиртэй (нум хагас) газрыг дөрвөлжин буюу дугуй хэлбэртэйгээр гүн рүүгээ 1 м-ээс доошгүй малтаж тавина. Ханангын ханачилсан модыг хооронд нь үдээрээр сайн үдэж нөгөө малтсан нүхний амсрыг таглан тавьж түүнийгээ мэдэгдэхгүй тулд ханангын дөрвөлжин нүхийг дэрс зэгс өвсөөр өнгөлөн далдалж орхидог байна.

Усанд орж байгаа мянга мянган зээрээс гадна хоол эрсэн өлөн чоно хэрэн тэнүүчилж явсаар санамсаргүй энэхүү ханангад орох ч удаа байдаг гэнэ. Эдгээр ангууд нь ханангын дөрвөлжин нүхүүдэд эхлээд урд нэг буюу хоёр хөл нь юуны урьд цөмрөн ороход сочиж сандарсан амьтан хойд хоёр хөл дээрээ хүч авч гарахаар урд хөлөө дутуу хагас сугалах боловч ухарч чаддаггүй, урагшаа үсрэн гарах гэж улам урагшлахад дөрвөн хөл нь дөрвүүлээ улаан суга цавиа хүртэл цөмрөн орж ханангын хавтгай дээр гэдсээрээ тээгдэн хэвтдэг байна.

Ийнхүү улаан суга цавиа хүртэл орсон ямар нэгэн амьтан өөдөө суга үсрэн гарч чаддаггүй байна. Гол учир нь иймэрхүү байдлаар ханангын завсраар дөрвөн хөл нь ямар нэгэн тулах цэггүй доргош хий унжиж байгаагаас тийрэлтийн хүчээ авч үсрэн гарч чадахгүй байдаг байна.

Харин ханангыг анх хийхдээ ямар анд зориулж байгаагаар модны хэмжээг тохируулан бэлтгэдэг байна. Тэр ангийн хүнд хөнгөн, хүчин чадал, биеийн хэмжээг харгалзан модны нарийн бүдүүн, урт богино, [fol. 9) recto] дөрвөлжин нүхний хэмжээ зэргийг нарийн тохируулж хийх нь хамгийн чухал байдаг байна. Жишээ нь, цагаан зээрийн хамгийн том ооно хоёрын зэрэг орсон ч ханангын мод хугарахгүй байхыг бодож сайн чанарын бургаасаар хийдэг байна.

Ханангынхаа хана бургаас хугарах эвхэрэх буюу нэг булан нь мултарч нүх рүүгээ унах хазайх зэргээр орсон ангаа алдахгүйн тулд ханангын дөрвөн ирмэгт урт нарийн

модоор эмжсэн байдлаар хөвөөлөн уяж тавьдаг байна. Газрын хөрс нь нуранги биш үндэс сайтай Дорнодын нутагт бэлтгэсэн нүхээ зээр, чоно зэрэг дунд хэмжээний анг барих агнахад нэлээд удаан хугацаагаар хэрэглэж болдог байна. Жишээ нь, түрүүчийн орсон ангаа гарган аваад дахин өнгөлөн далдалж тавихад дараагийн ан орох учир Алтайн цаад элсэн хөрстэй нуранги газар бэлтгэсэн *бүдрэг* хэмээх унангийг бодоход малтсан нүх нь тийм амархан нурдаггүй учир ашгаар илүүтэй байна.

Зун өвлийн ан ус унд шаардахгүй цагт ханангаа хураан авдаг бөгөөд ийм хана хэлбэрийн ханангыг эвхэж аваад явахад авсаархан хөнгөн учир хэрэгтэй цагтаа агнуурт тавиад хэрэг өнгөрөхөөр нь хурааж аваад байхад аль ч талаараа бэрхшээлгүй орлого олзоор тийм ч муугүй учраас ан агнуурт нэлээд хожим болтол хэрэглэж байсан байна.

Ханангын урт өргөн нь хааш хаашаа 2, 3 м хиртэй, ханангын дөрвөлжин нүх нь 10-12 см зайтай олон тооны ханачилсан дөрвөлжин нүхтэйгээрээ нэг ёсны гэрийн хана шиг байх бөгөөд ялгавар нь гэрийн ханыг бодоход тэгш шулуун байх ба малтсан нүхнийхээ амсрыг бүрэн бүтээж хүрэлцэх хэмжээний урт богино нь тохирсон байх ёстой байна.

Ханангын доорхи газрыг дугуй буюу дөрвөлжин [fol. 9] verso хэлбэрээр малтаж болдог байна. Харин нүхний гүн нь барагцаалбал нэг, хоёр метр хиртэй байх нь ханангын завсраар орсон зээр гөрөөсний хөл газар хүрэхгүй хий унжиж байлгахгаар тохируулдаг байна. Харин ханангын доорхи нүх нь дөрвөлжин байснаас дугуй хэлбэртэй байх нь тохиромжоор илүү байдаг байна. Учир нь дугуй нүхэн дээр ханангыг тавихад дорогш хotoйх буюу мултрах аюул гардаггүй байна. Мөн аль ч талаас ан орж болдгоороо дөрвөлжнөөс дугуй нь арай илүү ашигтай байдаг байна.

[fol. ... recto] **Чонын хориг занга.** Өндрөөрөө 1 м орчим хааш хаашаа 7 м зайтай дугуй хэлбэртэй хашаа барьж хашааны гол дунд нь 3 м гүн дугуй нүхийг гадуур хашаанаасаа 1,5 м дотуур малтаж энэхүү

намхан дугуй хашааны толгой дээрээс нөгөө гүн нүхний амсар руу хагас метр хиртэй оруулж сайн харуулдаж өнгөлсөн банзаар тойруулан битүү хучаад үзэхэд гол руугаа хэт ташуу байдалтай болно. Жишээ нь, дотор талын хэлбэр төрх нь шингэн зүйл савнаас лонхонд хийдэг цорго шиг дугуй ташуу гүн хонхор (конус) болдог байна. Үүнд орсон чоно эргэж гарна гэх найдваргүй худагт унасан юм шиг болдог байна.

Гадуур хашаа, дотуур ташуу хучлага хоёрын завсар хооронд хэвтэр засаж тэжээл тавьсан ямааг тусгай сайн хийсэн хаалгаар оруулж орхидог байна. Ингээд ойр хавьд нь хүн амьтангүй болохоор ямаа хааяа хааяа майлдаг, ялангуяа амьтны чимээ гарахад бүр ч майлах нь их болдог байна. Үүний чимээ үнэрээр өлөн чононууд эрхгүй ирж эргэн тойрон шиншилж ойртохыг ямаа мэдэж чонын чимээ үнэрээр майлахаа больж хашаан дотроо тойрон гүйнэ. Үүнийг барьж идэх гэсэн чононууд тэсч ядахдаа ямааг барьж идэхээр шууд хашаан дээгүүр харайж ордог.

Ер нь хашаатай хонинд чоно хашаан дээгүүр орж дотор нь сүйтгэдэг амьтан бөгөөд гэхдээ чоно нь муу санаатай амьтны хувьд хашаан дээгүүр орохдоо аль намхан газраар биеэ хашаанд хүргэхгүй хий дүүлэн ордог тул тэр ёсоор ийм хашаан дээгүүр нэгэнт дүүлэн харайсан чоно биеэ татаж авч чадалгүй ташуу банзны доод ирмэг шүргэн буунгуут тэр дороо гулсаж нүхний ёроолд унадаг байна. Энэ удаа хэдэн чоно ирсэн байна, цөм бие биеийн хойноос харайсаар бүгд ордог байна.

Ийм хашаа нүх хавсарсан хориг зангыг чонын тогтмол гүйдэлтэй газар юм уу, ялангуяа чонын цуглааны үед чоно ихтэй, нэлээд зэлүүд газар зохион байгуулсан байхад сүргээр чонын олзтой байх явдал ч байдаг байна.

[fol.... verso] Давчуу газар олон чоно орсон байхад бие биеэ хэмхэх, ялангуяа цуглааны цагийн чоно гичийгээ булаалдаж ихэнхээ хэмхэж барьдаг байна. Учир нь, нэгд, бага зайд олон чоно орсон, хоёрт, ороо цуглааны үе тул гичийгээ харамлах, гуравт, олон газрын чононууд, дөрөвт, гарч чадахгүйн уур зэргээс аль чадалтай нь бие биеэ барьдаг

байна. Ийм аргыг ой модтой хангай нутагт хэрэглэж ирсэн байна.

[fol... recto] *Хонины хашаан дотор тавих хананга*. Чоно нь их хүч бяр зарцуулж төвөг удахгүйгээр хүч тарга сайтай, мөн ч зөөлөн махтай амьтныг барьж идэх сонирхолтой байдаг. Гэвч намар орой гарвага зурам ичихээр идэх хоол нь ховордож ирэхээр хариуллага маллагаа муутай айлын малд довтлох буюу шөнийн цагт хот эргэж ноходтой хөөцөлдөн хонох явдал үргэлжийн үзэгдэл болдог. Хааяа хааяа гэнэдүүлэн хоттой хонинд орж сүйтгэх учир малчид энэ үеэр хашаагүй ил задгай хотолдог хонь малаа манах шаардлагатай байдаг. Манахгүй бол хонь үхрүүд нь шөнө бэлчих юмуу, чононд хөөгдөн хядуулах явдал гардаг удаа байдаг.

Гэтэл зарим айлууд хүн бүл муутайгаас хашаа, нохой хоёртоо найдаж байх ч явдал гардаг, үүний нь мэдсэн юм шиг ялангуяа, цас бороотой шөнө хүмүүсийн энэ сул талыг ашиглан хашаатай хонинд орох явдал бишгүй үзэгддэг. Гэхдээ чоно нь айлын хашаатай хонинд нэг удаа орж сурвал хонь барьж чадсан ч байг, эс барьж чадсан ч байг, дахин орох нь дамжиггүй байдаг.

Ингэж хашаан дээгүүр дахиж харайж орохдоо урьдын орсон газраар заавал ордог, үүнээс өөр аль нэг тохиолдсон газраар огт ордоггүйг манай малчин ардууд хэзээний мэддэг тул, тэр нэгэн удаа орохдоо чухам хашааны аль байраар давж орсныг мэдэж аваад, харайж орсон байрын дотор талд дөрвөн богино шон суулгах буюу гадас шааж түүндээ гэрийн ханыг дөрвөн тийш нь [fol. ... recto] тэлж уядаг байна.

Үүгээр урьд нь орсон чоно дахин орохоор хашаан дээгүүр харайж буухдаа дөрвөн хөл нь яг хавтгай ханан дээр тусах тул ханын дөрвөлжин нүхээр дөрвөн хөл нь суга цавиа хүртэл ороод хөлийн ул тавхай нь тулах юмгүй учир хий дүүжлэгдэн гарч чадахгүйд хүрдэг байна.

Ийнхүү айлын хотонд амь өрсөлдөн орж байгаа чоно нь ганцаараа биш хоёроос дээш

байдаг тул нэг нь нохдын анхаарлыг өөр тийш нь татаж ноходтой хөөцөлдөж байхад нөгөө хэсэг нь хашаанд ордог тул түрүүчийн орсны хойноос дараачийн чоно нэгэн адил харайж хананд ордог явдал нэг биш удаа үзэгдэж байсан байна.

Энэ учраас зарим айлууд хонины хашаагаа зарим хэсгээр зориуд өндөр барьж түүндээ элдэв зүйлийг зүүж өлгөж чонын ирэх зүгт хэд хэдэн байрыг намдуу барьж түүний дотор талд ханууд дээрх ёсоор урьдчилан бэлтгэдэг ёс ч байв. Ийнхүү хөндий тавьсан ханын доогуур хонь ямаа саадгүй ордог тул хашааны зайд ямар ч нөлөө үзүүлдэггүй байна.

Ер нь чоныг хашаанд орохоор хонь хашаа хороогоо дэлбэ татах хүртэл үргэж бужигнах ба ноход боргон хуцаж ер биш үймээн шуугиан бий болох тул малчид энэ завсар гэрийн ацтай хусан баганыг авч гараад ханын завсраар дөрвөн хөл нь ороод гарч чадахгүй дэмий л овгонож [fol. ... recto] байгаа чоныг тэр дор нь эрэгтэй эмэгтэй ялгаагүй цохиж алдаг байжээ. Хүн бүл муутай айл эмэгтэйчүүд байх тул гэрийн баганаар цохиж алдаг байна.

Энэ аргыг Хэнтий аймгийн Баянтэрэм² сумын нутагт дээр үеэс хэрэглэж байсан тухай мөн сумын харьяат одоо Иргэний Агаарын Тээврийн нисэх онгоцны хурандаа Хуучаан тодорхой мэдэх тул ярьж өгсөн юм. Үүнээс үзэхэд Дорнод аймгийн Матад суманд газар ухаж тавьж байсан ханангыг үүнтэй зэрэгцүүлэн үзэхэд иймэрхүү хана буюу зориуд бэлтгэсэн ханангыг Монголын дорнод нутагт эрт дээр цагаас уламжлагдан хэрэглэсээр ирсэн энэ хоёр адил төстэй баримт нь бие биеийгээ нотлож байна гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Үүнийг ганцхан Монголын дорнод нутагт хэрэглээд зогсоогүй биз. Ямар ч болов монгол гэрт амьдардаг малчин ардуудын дунд дэлгэрч гэрийнхээ ханаар хүртэл эрт дээр цагаас эхлэн агнуур хийх буюу хот малаа

² 1942 он хүртэл Хэнтий аймгийн Баянтэрэм сум гэж байсан. Одоо Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нэгэн баг болжээ (У.Э.).

хамгаалахад ашиглаж байсан агнуурын аргын нэг хэлбэрт тооцогдон орох ёстой байна.

[fol....recto] *Тэмээний хорголоор агнах арга*. Өвлийн дүн хүйтний улиралд талархаг нутагт үнэг, ялангуяа хярс нь өдрийн цагт нүхэнд хоргодож байдаг. Ер нь ямар нэгэн нүх нь газрын өнгөн хөрснөөс нүхний мухар тийш уруудах байдалтай алгуур дорогшилно. Энэ учраас үнэг хярсны нүхэнд өө сэвгүй бөв бөөрөнхий зүйлийг ам руу нь тавихад нүхний мухар хүртэл ямар ч саадгүй бөмбөрөн өнхөрсөөр хүрдэг билээ. Үүнийг хүмүүс аль эрт мэдсэнээр нүхэнд байгаа үнэг хярсны агнахын тулд тэмээний хөлдүү хорголыг үнэг хярс орсон нүхний амсар руу цувуулан урсгаж хийдэг байна.

Ийм маягаар хийгээд байхад түрүүчийн хоргол хоржигнон урссаар нүхний мухарт хэвтэж байгаа үнэг хярсны хүртэл хөлдүү хорголууд нь бие биеэ түрэн өнхрөх дуу чимээ гарган урсан орсоор байгаа нь тодорхой мэдэгдэнэ. Ингэж нүхийг төдөлгүй чигжэн дүүргэнэ. Гэхдээ нүхэнд байгаа үнэг хярснаа хорголын наад захад гарч ирэх боломжтой зай үлдээж сая нүхнийнхээ амыг чулуугаар гоц сайн түгжиж орхино.

Ийнхүү хорголоор бөглөгдсөн нүхний мухарт байгаа үнэг хярс нь сийрэг хорголын завсраар агаар авсаар байх учир нүхний мухарт байгаа амьтан тэр даруйдаа агаар дутагдаж бүтэж үхдэггүй, харин удах тутмаа агаар муудах тул нүхний гадна талын дуу чимээ бүрмөсөн дарагдсаны дараа чигжигдсэн хөлдүү хорголоо хөнгөн хялбар малтсаар нүхний амсар тийш урагшилсаар ирнэ.

[fol. ... verso] Зарим үнэг хярс нь агаар дутагдахгүй байх бол тэндээсээ төдий л хурдан гарч ирдэггүй боловч 3 хоногийн дотор заавал хорголын наад захад гарч ирсэн байдаг байна.

Хэдий нүхний амсарт тулж ирэвч чулуун түгжээнд хоригдож хэвтэнэ. Нэгэнт ингэж ирсэн үнэг буюу хярс дахин буцаж нүхнийхээ мухар руу хорголоо малтах ёсгүй, малтлаа ч гэсэн уруудуу ташуу нүхэнд чигжрэн орсон хөлдүү хоргол буцаж урсаад байдаг байна.

Ийнхүү тэмээний хорголоор агнах энэ аргыг Хэнтий аймгийн Баянтэрэм сумын

нутагт эртнээс уламжлагдан хэрэглэсээр ирсэн учир ийм аргаар үнэг хярс агнаж байсан хүний нэг бол мөн сумын харьяат бөгөөд одоо Иргэний Агаарын Тээврийн нисэх онгоцны хурандаа Хуучаан нутагт байхдаа энэ аргыг хэрэглэж агнуур хийж тухай бүртээ амжилт олсоор байсан хүн тул энэ талаар тодорхой мэддэгийн хувьд ярьж өгсөн юм.

Ер нь эрт цагийн агнуурын янз бүрийн арга хэлбэр, багаж зэвсэг, түүний үлдэц уламжлалын үлдэгдэл нь орчин цагийн хөгжилтэй зэвсэг багаж гарч ирснээр нийгмийн хэрэгцээнээс аль эрт хасагдаж зөвхөн түүний үлдэц буюу домог яриа үлджээ. Гэвч үүнээс үндэслэн зарим хүмүүс туршлагын чанартай хааяа хэрэглэж үзсэн нь ийм багаж зэвсгийн яаж хэрэглэж байсан, түүнийг зохион байгуулах аргыг ийнхүү мэдэх хүмүүс байгаад оршино. Харин одоо хүртэл хуучин аргаа хэвээр хэрэглэж байгаагаар ойлговол буруу болно. Гэвч туршин үзэхэд буруудах тал байхгүй болно.

[fol. ... recto] *Хутга мэсэн хүүлүүр*. Ийм багаж зэвсгээр 1900 он хүртэл Хэнтий уул, түүний салбар газруудаар ганц гахай агнахад хэрэглэж байсан мэдээ баримт байдаг юм.

Гахай бол жил бүрийн хавар ирдэг буюу манай нутаг дээгүүр нисэн өнгөрдөг галууны цуваа шиг агаарын замаар тахирлан мурийсаар хүрэх газартаа очдогийн адил эрт галавын үед нэгэнт тогтоогдсон замаа алдахгүй нисдэг шиг гахай ч тэр тогтсон зөргөө алдахгүй тахирлан мурийж газрын аль битүү бэрхийг дагаж цувран гүйдэг амьтан юм. Үүнийг хүмүүс олон мянган жилийн амьдралын судалгаагаар мэдэж авсны үр дүнд саяхан эндээс хөдөлсөн гахайн сүрэг хаагуур хаагуур дамжин явсаар хаа хүрч тогтохыг хүртэл тодорхой мэддэг болсноос хойш аль ойр бартаа багатай газраар гахайнхаа өмнө орж замыг тосох буюу тогтох ёстой газар дээр нь гүйцэж очих зэргээр агнуур хийдэг болсон байна.

Энэ бүгдээс гахайн зайлшгүй явдаг зам дээр нь хөндлөн унаж газар наалдсан модон дээгүүр алхах буюу харайж гардаг байсан бол түүний дээр нь хоёр талдаа иртэй маш хурц хугтануудыг мөнхүү модонд үзүүр ирий нь

өөд нь харуулан өндөр намыг тохируулан ишээр нь зоож орхисны дараа гахайнуудаа байгаа газраас нь агнах журмаар хөдөлгөдөг байна.

[fol. ... verso] Ийнхүү хөдөлгөсөн гахайнууд мөнхүү зөргөөр цувран явсаар хутга зоосон модонд тулгарч дээгүүр нь түрүүчийн гахай харайж гарангуут гэдсээ хүү татуулснаасаа болж хар хурдаараа цааш давхихад хойдох гахайнууд нь бие биеийн хойноос цувран харайж нэгэн адил гэдсээ хага зүсүүлэн цөм төдий л холдож чадалгүй ганзага мялаадаг байна.

Ийм аргаар агнаж байсан хүмүүс гэвэл Сэлэнгэ аймгийн Баян хаан, Ар Өвөр Бөгдээ, Хүдэрийн баруун нуруунуудаар агнуур хийдэг байсан хуучны нэрд гарсан хашир анчин Мятав гэдэг хүн нэг удаа 10 гаруй гахай нэг дор агнаад байсныг партизан Ж.Дамдин нүдээр үзэж байсан тул тодорхой ярьсан юм.

Мөн Хэнтий хааны ар өврөөр 80 нас хүртлээ ан хийж амьдарч явсан хуучны алдартай анчин Хорол гэдэг хүн 1930 оны үед өөрийгөө дагаж ан хийж сурсан залуу анчин

Самдан нарт эртний агнуурын түүх, сайн сайн анчдын тухай дурсан ярихдаа хутгаар агнуур хийдэг ийм аргыг өөрөө ч хэрэглэж амжилт олж үзсэн тухайгаа тодорхой ярьж байсан учир бид нар цөм сонирхон байж сонсож байсан маань миний санаанаас гардаггүй юм.

Ер нь Хорол гуай бол ганц гахай ч биш төрөл бүрийн ангийн өндөр мэдлэгтэй хүн байсан нь хүмүүст гайхагдаж байсан юм. Түүний хэлж зааж сургаж байсан бүхэн яг үнэн зөв байдагсан гэж Улсын Төв Музейн чихмэлчин ажилтай [fol. ... recto] Самдан одоо ярьж байгаагаас үзэхэд ийнхүү хутгаар агнах арга нь зөвхөн сүүлийн үед бий болсон биш манай оронд металл зэвсэг хэрэглэх болсон үеэс эхлэн янз бүрийн зэвсэг түүний дотроос хоёр талдаа иртэй хурц илдэн хутгаар агнуур хийж эхэлсний үргэлжлэл болов уу.

Харин буу зэрэг нарийн хурц зэвсэг гарснаас хойш анчид тэр бүрий ийм төвөгтэй аргыг хэрэглэх нь хаягдаж энэ мэт тодорхой мэдлэг, нүсэр хөдөлмөр шаардагдсан арга бүхэн аяндаа нийгмийн хөгжлөөс ямар нэгэн үед хасагдсаар ирсэн байна.

НОМ ЗҮЙ

- Баарай Н., Төмөр-Очир С. 1974. Улсын Төв Музейн үүсэж хөгжсөн түүхээс. *Studia Museologica*. Tomus II, Fasc. 1, Улаанбаатар, 4-23.
- Бадам Ш., 1965. Залуу анчдад зөвлөгөө. Улаанбаатар.
- Гонгор Д., 1978. *Халх товчоон*. II боть: Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (XI-XVII зуун). Улаанбаатар.
- Дамдин Ж., 1958. *Ховор амьтны мөрөөр*. Улаанбаатар.
- Дамдин Ж., 1963. *Буурал анчны тэмдэглэл*. Улаанбаатар.
- Дамдин Ж., 1975. *Анчны тэмдэглэл*. Улаанбаатар.
- Даш Я., Гонгор Ш., 1965. *Ан агнуурын товч мэдэгдэхүүн*. Улаанбаатар.
- Лувсан С., 1986. *Монгол анчны тэмдэглэл*. Улаанбаатар.
- Монгол ардын журамт цэргийн дуртгалууд*, 1982. Тэргүүн дэвтэр. Түүхийн ухааны дэд эрдэмтэн С.Уртнасан, Г.Цэрэндорж нар боловсруулан бэлтгэж академич Ш.Нацагдорж редакторлов. Улаанбаатар.
- Монголын музей*. Архивын баримтын эмхэтгэл (1921-2008), 2012. Эмхэтгэсэн Х.Мэндсайхан, М.Цэрмаа, С.Буянжаргал. Улаанбаатар.
- Төмөр-Очир С., 1968. Улсын Төв Музейн үзмэрт байгаа гал асаагуурын мод. *Studia Museologica*. Tomus I, Fasc. 5, Улаанбаатар, 55-59.
- Төмөр-Очир С., 1977а. Улсын Төв Музейд байгаа нэгэн тугийн тухай. *Studia Museologica*. Tomus III, Улаанбаатар, 38-44.
- Төмөр-Очир С., 1977б. Монголчууд галт зэвсэгтэй болсон нь. *Studia Museologica*. Tomus III, Улаанбаатар, 68-71.

SUMMARY

ULAMBAYAR ERDENEBAT

MONGOLIANS USED TRAPS FOR HUNTING
(About a newly found manuscript)

Using traps is one of the ancient ways for hunting. Mongolians used to prepare a big hole covered by grass as a trap for overtaking and throwing when hunting on forest hoofed animals such as elk or deer. For hunting small animals, a door or a hole with lock in the ground was prepared. In other words, as small animal enters or crawls to the prepared trap, a lock moves and heavy things fall down on it. Many ways of hunting as well as for hindering an animal in a hole with wall on its edge was dig near to the animal's watering places in the area of steppe. Since hunting instruments such as saili, trap /zanga/, and reaping-hooks /haj/ are considered as dangerous weapons for human and herds, it was prohibited by legislations for using them. At the same time, way of using those utensils was almost forgotten due to development of other hunting utensils. By this article, a newly found manuscript named "Traps used for hunting" is introduced for readers and researchers. The script was hand written in the second half of the last century.

1

Агнуурт занга хэрэглэж байсан нь (Σ)

Зангыг эрт цагаас өргөн хэрэглэнэ ирэнг бололтой үүнд дарах занга, цохих занга, толгойт занга, торон занга, хорь занга, хашаан занга, хавдур занга, хөшрөг бүтэц амсгал занга, исорт бүтэц исэгтэй занга, гэх зэрэг олон төрлийн зангуудыг газар орны байдал түүнд хэрэглэгдэх материалын байдалд тохирдуулан тухайн найзтайгаа хөгжилзүүдийн дагуу янз бүрийн занга гарч хэрэглэгдэнэ байжээ.

Хэрэглэхдээ ан амьтны байдалд тохирдуулан буган занга, үшигэн занга, гончин занга, гандган занга, хүдэрмэ занга, гахайн занга, баавгайн занга, буга-Хандгайн занга гэнэ олон төрлийн амьтны нэгтгэл түүнд бүтэц түүнтэй бэрхцээс анд тус бүрийн хэмжээнд тохирдуулан Хүнд хонгон майг хийж зохион байгуулалт нь өөр өөр байдаг байна. Өргөн үед зангыг тэр бүр тавьдаг үгүй болжээ. Ер нь Сааль-занга зэрэг дарах харвах зэвсэг амьтанд, хүмүүсийн амьт насанд хонгол хүрээдэг гэр эртнээс авлааг хуучин цаадлан хориглосон зэвсэг юм.

А Буган зангын тухай товч үгүүлэх нь буга маань манай орны Хөтний, Хөвсгөлийн ай тайга түүний Салбар уулаар Элдэг орошсоор ирэнг түүн эрт дээр цагаас үеийн Хөмсөг Сайханд болж дотгоод, гадаадын Хэрэгцээг зориулж аянасаар иржээ. Зарим газрын бугага хар, монгол сөртэй хар байхад зарим газар Хүрт, Байвар Шаргалдуу байдаг юм. Бүгдээ ажиглахад ирэнгээ Зорихдаа өвлийн жавартай хүртээд голдуу газрынхаа нам доод тал

Зураг 1: “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх гар бичмэлийн нэгдүгээр тал [fol. 1 recto]

үртэй байжээ: Халгай дэлхийн хайр хийж, жадар соёо
 шүүтэй, хар сөртийн халдуй саарал зансоор, хашаа хоргоий
 шинэ хангай дүрэм соёрхоо, гэнэ дорвол зүгт сайсаж
 орсон олз аривин дээр, өнцө муулар гэж хэлээ тэвхээ
 сайдаг байжээ. Англи зэрүү хэмтэх доржийн үг юмаа.

1923 онд манайх Төрөлжийн шар гэвсэн газар өвөлжсөн тэр
 өвөл манай айм өвөлжсөн айлуудын дунд Хэрэмийн Намын
 хэмтэх шинэ зануу англи байлаа, Би түүнийг даган өдөр бүр
 хоол өйр хэрэм агнахыг сурах саатай явдаг байлаа.

Шинэжиг Явахдаа бага мухарын модон дотор өйр хавийн төмөр
 тавих хаасан занган нүүдэр үзэх тэр үед юу болсныг мэдэх
 Намын хаасаа асууваг занга гэдэг юм гэж анх удаа мэдэж
 авсан юм, Ингээд занган хэрхэн тавьдаг Энэ занга өмөр
 анд тавьсан зоргоо бүрэн мэдэх болсан Харин Энэ занга
 өн удаа үнэ мод нь илжарсан байсан юм,
 дараа өвөл нь хайт сайхан байхад хөвгийн алдартай англи
 зэрүү дорги Дунд нар ~~Миний~~ ах Миний ах Шаравтай
 анд гархаар манайх иржэ ангийн тухай урьдын нэртэй
 сайн ангийн тухай өөрөө заанд занга тавих байсан
 зэрэгт сонеход миний үзсэн занга зоргоо оролдуулж байв
 Би тэр үед бага байсан үнэ тэдний ярианд орох байтгай
 асуух эрх зэрэгт хүрээгүй байлаа, Харин зангань
 тухай тавих ёс хэлэх үг зэрэгт өнцө сонирхож бэлээ,
 муура манган үг болхоор хүрхэг багалууд татгалз
 яридаг байсан юм,

Зураг 2: “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх гар бичмэлийн аравдугаар тал [fol.5 recto]

Хоньны хашаан дотор тавих

Хананга

Гонь нь их хүч дэр зарцуулж төвөг удахгүйгаар хүч тарга
 Сайтай мөн зөвхөн махтай амттай баримд идэх сонирхолтой
 байдаг, гэвч намар ороо тарвага зурам ихээр идэх хоол нь
 ховордож ихээр харуулага маллага муутай айлант малд довтоох
 буюу шонийн цагт хот эргэж ноходтой хөөсөлдөн хонь
 явдаг үрэлтийн үзэгдэл болдог, хав хав гэнгүүрэн хоттой
 хонинд орж сүлжээх үеэр малчид энэ үеэр хашаагүй ил
 задган хөтөлдөг хонь малаа малах шаардлагаатай байдаг
 малахгүй бол хонь үхэрүүд нь шонь билгэх юм уу, Гоньд
 хөөсдөн хидуулах явдал гардаг удаа байдаг,

Тэгээ зарим айлууд хүч бүл муутайгаас хашаа, нохой
 хоёртой найдаж байх э явдал бол гардаг, үүнийг нь мэдсэн юм
 ингэж ялангуяа нас бороотой шонь хүмүүсийн энэ сүл талыг
 амьттай хашаатай хонинд орох явдал билүүгүй үзэгдэл, гэхдээ
 гонь нь айлан хашаатай хонинд ил удаа орж сурвал
 хонь баримд гадсан э байг эс баримд гадсан э байг дахин
 орох нь дамжиг үгүй байдаг, Ингэж хашаан дээгүүр дахин
 харим орохдаа үрэгдэн орсон газраар заавал ордог, үүнээс
 өөр аль ил дохисдсан газраар орж ордог үгүйг мөнх
 малч арьдууд хэзээний мэдсэн тул, тэр нэгэн удаа орохдаа
 гухам хашааны аль байраар дахин орсны мэдэж авсанд,
 харайцг орсон байрны дотор талд дөрвөн бэлгэ мөн сүүлч
 буюу гадас маачи түнцдэг гүйн ханыг дөрвөн тийш нь

Зураг 3: “Агнуурт занга хэрэглэж байсан нь” хэмээх гар бичмэлийн гучин хоёрдугаар тал [fol.... recto]

Ийнхүү хөдөлгөөнт Тахайнууд мөнхүү зөргөөр цувран явсаар
 Хутга зовсон модонд төмөр дээгүүр нь туржигийн гажал
 харамж гаргалууд гэдгээ хүч дагуулжээ. Дэлгэц хар хүрдээр
 ийнхүү давхихаг хайтах Тахайнууд нь бие биений хайноос
 цувран харамж илэж адил гэдгээ хаг зүсүүрэн ивэн модонд
 хөддөн гадгалууд галзаг милаадаг байна.

Ийн аргаар агнаж байсан хүмүүс гэдэг Сэлэнгэ аймгийн
 Бадан хаан, ар өвөр бөгдөө, хүрдийн даруучи нурууцур
 агнуур хийдэг байсан
 Хуучин нэгд гаргал хашир ангийн Мидав гэдэг хүч
 нэг удаа 40 гаруй талбай нэг агур агнаад
~~Хуучин~~ хийдэг байсныг Тартигал Ж Дамдин нүүдэр үзэж
 байсан тус төдөрхөн арьсан юм.

Мөн Хэнтий хааны ар өвөрөөр 80 нас хүртэлхи ан хийж
 амтарга явсан Хуучин алдартай ангийн Хорол гэдэг хүч
 1930 онд үед өөрийнхөө дэргэн ан хийж сурсан залуу ангийн
 Сандан нарн эртний агнуурт түүх, сайн сайн ангийн
 тухай дурсал дрихдаа Хутгаар агнуур хийдэг Ийн аргыг
 өөрөөг хэрэглэж амшигтай олж үзсэн тухайгаа төдөрхөн
 арьж байсан үгэр бид нар ивэн санирхай байж сансонж
 байсан маань мөнхөн Санаснага гардаг үгэр юм.

Ер нь Хорол гүжр бол ганц Тахайг бие төрөл бүрийн
 ангийн өдөр мэддэгтэй хүч байсан нь хүмүүст гайхалдаж
 байсан юм

түүний хэлж зааж сургаж байсан бүхэн эг үгэн зөв
 байдаг сэтгэл үгэн үгсэн төв музейн Гижимэлтэн ажилтай

Зураг 4: "Агнуурт занга хэрэглэж байсан нь" хэмээх гар бичмэлийн гучин зургаадугаар тал [fol.... verso]